

БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ

I БӨЛӨГ ГЭГЭЭРЭХ ЗАМ

I СЭТГЭЛ САНААГАА АРИУСГАХ

1. Хүн, төөрөгдөл зовлон зүдүүрийн эх булаг болсон хорвоогийн шунал тачаалын эрхшээлд оршмой. Тэдгээрийн эрхшээлээс ангижрах таван арга буй.

Нэгдүгээрт, эд юмсыг үнэн зөв харах, учир шалтгааны хуулийг ухааран мэдэх явдал болой. Бүх зовлон зүдүүрийн эх булаг нь сэтгэлийг эзэмдэх хорвоогийн шунал тачаал мөнийг мэдэж, түүнийг устгаж арилгавал зовлон зүдүүрээс сая ангижирна.

Хүн эд юмыг буруу үзэж харах тул, өөрийнхөө "Би"-г оршдог хэмээн бодож, учир шалтгааны хуулийг үл хэрэгсэнэ. Иим буруу ташаа ухаарал, шунал тачаалын шалтгаан болж, хүн төөрөлдөж, зовж зүдэрнэ.

Хоёрдугаарт, хүслээ хазаарласнаар хорвоогийн шунал тачаалыг номхотгоно. Нүд, чих, хамар, хэл, бие хийгээд бодол санааны нөлөөгөөр үүсдэг хүслийг эрүүл ухаанаар дарж шунал тачаалын үндсийг тас цавчих хэрэгтэй.

Гуравдугаарт, эд юмсыг хэрэглэхдээ, тэдгээрийг хэрхэн ашиглах тухай зөв ойлгож төсөөлөх учиртай. Өөрийнхөө зугаа цэнгэлийг л бодож хувцас хунар өмсөж, хоол унд идэж ууж болохгүй. Хувцас хунар бол нүцгэн биеийг бусдын нүднээс далдлах, халуун, хүйтнээс хамгаалах зориулалттай. Хоол хүнс нь Бурхан багшийн сургаалыг дагаж буй хүний бие махбодыг тэжээхэд зориулагдана. Эд юмсад хүн ингэж зөв хандвал шунал тачаал санаа сэтгэлд нь буй болохгүй.

Дөрөвдүгээрт, бүх юманд тэвчээр хэрэгтэй. Халах хөрөх, өлсөх цангахыг тэвчиж, доромжлол, гүтгэлгийг хүлцэж чадвал хүнийг шатаадаг шунал тачаалын гал үл асна.

Тавдугаарт, аюулт дур сонирхлоос холхон байвал зохино. Ухаантай хүн эмнэг морь, эсвэл галзуу нохойд үл ойртох адил, осолтой газраас холхон байж, муу нөхдөөс зайлсхийх ёстой. Тэгвэл шунал тачаалын дөл бөхнө.

2. Ертөнцөд таван хүсэл буй. Тэдгээр нь, хүний нүд аятайхан хэлбэр галбирыг олж харах, чих аятайхан ая дууг сонсох, хамар аятайхан анхилууныг үнэрлэх, аятайхан амтнаас арааны шүлс асгарах, гар аятайхан юмыг мэдрэхэд буй болно.

Гэгээрэх зам

Олон хүн биеийн эдгээр хүсэлд автаж, хожмын үр дагаврыг үл бодон зугаа цэнгэлд умбадаг. Тэд ойн буга гөрөөчний зангуунд өртөх лүгээ адил шуламын эрхэнд орох бүлгээ. Үнэхээр эдгээр таван хүсэл нь хавх, зангуу лугаа адил юм. Хүн тэдгээрт баригдмагц сэтгэлд нь шунал тачаал төрж, зовж зүдэрч эхэлнэ. Эдгээр хүслээс болж гай гамшигтай тулгарвал, хавхнаасаа мултрах аргыг эрэх хэрэгтэй.

3. Хавхнаас гарах нэг бус арга буй. Тухайлбал, могой, матар, шувуу, нохой, үнэг, сармагчин буюу зан авираараа эвлэрэх аргагүй зургаан амьтныг барьж, бат бэх уяагаар холбон, хоёр үзүүрийг нь зангидаж тавья.

Зургаан амьтан өөр өөрийн төрөлх чанартаа хөтлөгдөн үүр үүр рүүгээ зүтгэнэ. Могой уул толгод руу, матар ус руу, шувуу тэнгэр рүү, нохой тосгон руу, үнэг эзгүй тал руу, сармагчин ой мод руу тэмүүлнэ. Амьтан бүр өөрийн зүг рүү зүтгэж, тэднээс хамгийн чадалтай нь дийлж, бусдыгаа үүр рүүгээ чирэн одно.

Үүнтэй адил хүн нүд харж, чих сонсож, хамар үнэрлэж, хэл амталж, арьс мэдэрч, сэтгэл хүсч буй юмныхаа эрхшээлд орно. Эдгээрээс хамгийн хүчтэй нь дийлж, хүн тэр хүслийн эрхшээлд бүрэн автана.

Хэрэв нөгөө зургаан амьтныг тус тусад нь газарт лав суулгасан баганаас чанга уявал эхлээд амьтан бүхэн өөрийн үүр рүү тэмүүлнэ. Удалгүй ядран сульдаж тус тусын баганын дэргэд хэвтэнэ.

Үүнтэй адил санаа сэтгэлээ барьж, удирдаж чадвал, бусад таван хүсэл нь хүний сэтгэлийг уруу татаж дийлэхгүй. Сэтгэлээ захирч чадсан хүн өнөөдөр, маргаашийн алинд ч зол жаргалтай амьдарна.

4. Хүмүүс хүслийн галд шатаж, алдар нэрийн хойноос хөөцөлдөнө. Тэд, асаахад уугин шатсаар алга болдог гүгэл лүгээ адил бүлгээ. Хэрэв Бурхан багшийн сургаалыг мартан нэр алдар, гавъяа шагналын хойноос хөөцөлдвөл хүний бие махбод үхэх мөхөхийн аюулд унаж, санаа сэтгэл гэмшин зовж шанална.

Нэр алдар, эд баялаг, гоё чамин юмны хойноос хөөцөлдөж буй хүн зөгийн бал түрхсэн хурц иртэй илдийг долоож буй хүүхэдтэй адил юм. Амтат балыг долоож байгаад хэлээ зүсч болзошгүй.

Хүсэлдээ автаж, ханахыг үл мэдэх хүн нь асаасан бамбарыг салхины эсрэг барьж яваа этгээдтэй адил юм. Тэрбээр өөрийн гар, бие юүгээ түлж шатаана.

Гэгээрэх зам

Шунаж хүсэх, үзэн ядах, мунхаг харанхуйн гурван хоронд идэгдсэн өөрийн сэтгэлд итгэж үл болно. Мөн сэтгэлээ дур зоргоор нь сул тавьж үл болно. Санаа сэтгэлээ хазаарлан барьж, хүсэл шуналдаа автахгүй байхыг хичээвээс зохино.

5. Гэгээрэхийг хүсч буй хүн хүслийн галаас зайлсхийх ёстой. Хуурай өвс үүрч яваа хүн талын түймрээс зугатахтай адил, гэгээрэхийг тэмүүлж буй хүн хүслийн галаас хол байх учиртай.

Хурц гоё өнгийн юм харчихаад санаа сэтгэл нь шохоорхохоос сэрэмжилж нүдээ ухан авч хаяхыг хүсэх хүн тэнэг. Энд хамгийн гол нь сэтгэл юм. Сэтгэлээ засаж чадвал түүнд захирагддаг нүдний гэм арилна. Бурхан багшийн сургаалыг дагахад хэцүү. Гэвч гэгээрэхийг хүсэх сэтгэлгүй амьдрах бүр ч хэцүү. Гэгээрлийг хүсдэггүй хүн энэ ертөнцөд төрөөд өтлөх, өвдөх, үхэхийн эцэс төгсгөлгүй зовлонд унана.

Бурхан багшийн сургаалыг дагагч хүн гүн гүнзгий шавар шавхай дундуур зоон дээрээ хүнд ачаа үүрээд гэлдэрч буй үхрээс үлгэр авах хэрэгтэй. Тэр үхэр зогсохыг мэдэхгүй урагшаа зүтгэнэ. Гагцхүү шавар шавхай өнгөрсний дараа саатаж амардаг. Хүслийн шавар шавхай бүр хэцүү ч, гэгээрэх зам мөрийг зөв сэтгэлтэй дагавал түүнийг туулсны

дараа зовлон зүдүүр дуусч, хөнгөрч амарна.

6. Гэгээрэх зам мөрийг дагаж яваа хүн амиа бодсон бардам зангаасаа салж, Бурхан багшийн сургаалын гэрэл гэгээг олох хэрэгтэй. Ямар ч үнэт эрдэнийг энэхүү буянтай зүйрлэх аргагүй.

Хүний бие бялдар эрүүл энх байж, гэр орон нь цэцэглэн хөгжиж, энх төвшин, амар амгаланг олохын тулд юуны өмнө сэтгэлээ хатамжилж, залж сурах хэрэгтэй. Хэрэв хүн сэтгэлээ залж чадаад Бурхан багшийн сургаалыг үзэхдээ баярлаж баясдаг болвол, өөрөө мэдэлгүй буяныг хураана.

Үнэт эрдэнэ газраас гарч, буян нь сайн үйлээс төрж, оюун ухааныг амар тайван, ариун тунгалаг сэтгэлээс олно. Зах хязгааргүй тал лугаа адил, төөрөгдөл дүүрэн амьдралыг эсэн мэнд даван туулахын тулд зам мөрөө оюуны гэрлээр гийгүүлэн, өөрийгөө буянаар хамгаалахыг хичээсүгэй.

Бурхан багш шунал хүсэл, үзэн ядах сэтгэл, харанхуй мунхгийн гурван хороос салахыг номлоно. Энэ бол зөв сургаал юм. Түүнийг дагасан хэн боловч сайн сайхан, зол жаргалтай аж төрнө.

7. Хүний сэтгэл, бодол санаагаа даган үргэлж хувирна. Шунал хүслийн тухай бодмогц, шунал хүсэл

Гэгээрэх зам

буй болно. Үзэн ядахын тухай бодмогц, үзэн ядах сэтгэл буй болно. Өшөө хонзонгийн тухай бодмогц, өшөө хонзон буй болдог

Намар ургац хураах цаг ойртоход малчин билчиж буй үхрээ хурааж, хашаанд нь оруулдаг. Тэрбээр үхэр нь ургацыг гишгичиж, түүнийг хурааж буй хүмүүсийн уур хилэнг хүргэж, зодуулж нүдүүлэх вий хэмээн болгоомжилсных билээ. Үүнтэй адил үйлээс болж гай гамшиг үүдэхийг харсан хүн сэтгэлээ хорьж, атгаг муу бодол санаанаас хагацах хэрэгтэй юм. Шунал хүсэл, үзэн ядах сэтгэл, өшөө хонзонг устгаад, үл хүсэж шунах, үл үзэн ядах, үл өшиж хонзогнохыг хичээх хэрэгтэй. Хавар хээр талд шинэхэн өвс ногоо соёолоход үхэрчин үхрээ бэлчээрт гаргана. Гэвч тэрбээр хариулгаа үл орхино.

Үүнтэй адил хүн ямагт санаа бодлоо хянаж, залж чиглүүлэх ёстой.

8. Нэгэнтээ Ялж төгс нөгчсөн багш Каусамби балгаст морилов. Түүнд хорон санаа агуулсан хүн, тус хотод амьдарч байжээ. Тэрбээр муу хүмүүсийг хахуулдаж энэ балгаст Амарлингуй оршигч багшийн тухай олиггүй цуу тараажээ. Хамгийг мэдэгч багшийн шавь нар балгасаар бадар барин явж гуйлга гуйхад тэдэнд юу ч өгөлгүй, урьдаас нь элдэв муухай үг хэлээр доромжилжээ.

Тэгээд Ананда, Бүхнийг айлдагч багшдаа хандаж: "Энэ балгаст үлдэх дэмий байна. Энэнээс дээр өөр балгаст очъё" гэв. Түүнчлэн ирсэн багш хариуд нь: "Ананда, дараагийн балгаст бидэнтэй мөн л ингэж харьцвал яана?" гэсэнд Ананда: "Тэгвэл түүний дараагийн балгаст очъё" хэмээв.

Бурхан багш. "Үгүй ээ, Ананда, иймэрхүү маягаар биднийг ямар ч балгаст утгаж магадгүй. Тэгвэл үргэлж нэг балгасаас нөгөө рүү явна. Миний бодоход биднийг доромжилж байвал тэвчиж, бүр чингэхээ больтол нь тэвчих хэрэгтэй. Харин үүнийхээ дараа өөр балгас руу явж болно. Ананда, чи сонсож бай. Бурхан багш хожих болон алдах, гүжирдүүлж гүтгүүлэх болон нэр алдар олох, магтаал болон доромжлол, зовж зүдрэх болон баярлаж баясах зэрэг найман ойлголтоос хол хөндий байдаг юм. Энэ бүхэн тун удахгүй улиран өнгөрнө" гэв.

II БУЯН ҮЙЛДЭХ

1. Гэгээрэхэд тэмүүлсэн хүн бие, хэл, сэтгэлээр үйлдэж буй үйлээ ариун байлгахыг ямагт бодох хэрэгтэй. Биеэр үйлдэж буй үйлээ ариун байлгах нь амьтны амь үл таслах, хулгай үл хийх, буруу үл хурьцах гэсэн ёс юм. Хэлний үйлийг ариун байлгах нь худал үл хэлэх, үл хараах, хоёр нүүр үл гаргах, үл

Гэгээрэх зам

чалчих хэмээсэн хэрэг.

Сэтгэлийн үйлийг ариун байлгах нь үл шунах, үл уурлах, эд юмсыг буруу үл харах хэрэг билээ.

Хэрэв сэтгэлд хир суувал ажил үйлс бузартаж, зовж зүдрэхээс зайлах аргагүй болно. Тиймээс санаа сэтгэлээ ариусгаж, аливаа үйлд биеэ барих нь чухал.

2. Эрт урьд цагт нэгэн баян бэлэвсэн эхнэр байжээ. Тэрбээр сайхан сэтгэлтэй, зөөлөн зан ааштай, төлөв даруу эмэгтэй тул, нэр хүнд ч сайтай байжээ. Мөн өөртэй нь адил ухаалаг, хөдөлмөрч нэг эмэгтэй зарцтай байжээ.

Нэгэнтээ зарц эмэгтэй бодсон нь: “Миний эзэгтэй бүгдийн хайр хүндлэл хүлээсэн билээ. Тэрбээр үнэхээр сайн хүн үү, эсхүл орчныхоо ачаар ийм болсон уу? Ямар ч гэсэн нэг сорьж үзье” хэмээв.

Маргааш өглөө зарц эмэгтэй оройхон босч, үдийн хоолны үеэр үзэгдэв. Эзэгтэй уцаарлангуйхан: "Өнөөдөр чи яагаад ийм орой босов" гэж асуув.

Зарц эмэгтэй; "Ганц хоёр удаа орой бослоо гэж бүү уцаарла" хэмээсэн нь эзэгтэйг улам хилэгнүүлэв.

Дараагийн өдөр зарц нь мөн хожуу босчээ. Уур

нь дүрэлзсэн эзэгтэй мод шүүрч, зарц эмэгтэйг цохиод авчээ. Хүмүүс энэ тухай мэдмэгцээ эзэгтэйг хүндэлж хайрлахаа больжээ.

3. Бүх хүмүүс энэ эзэгтэйтэй адил бүлгээ. Хэрэв орчин тойрон нь сайн бол, хүн ариун сэтгэлтэй, төлөв даруу, амгалан тайван байж чаддаг. Гэвч орчин тойрон нь хувиран өөрчлөгдөж, өөрийнх нь эсрэг хандвал тийм хэвээр үлдэж чадах уу?

Хүн өөрийнхөө тухай аягүй үг сонсож, хүмүүс өөрт нь илэрхий дайсагнаж, олигтойхон хувцас хунар, олигтойхон хоол унд үл олдож, сайн, муу ч өөрийн орох оронтой болж чадаагүй байхдаа урьдын адил амгалан тайван сэтгэлтэй хэвээр буянт үйлээ тасралтгүй үргэлжлүүлж чадах уу?

Орчин тойрон өөрт нь аятайхан байгаа нөхцөлд амгалан байдлаа хадгалж, сайн үйл бүтээж чаддаг бол тэрбээр сайн хүн бишээ. Гагцхүү Бурхан багшийн сургаалд баярлан баясаж, бие махбод, санаа сэтгэлийн төгс төгөлдөр чанарыг олсон нэг нь сайн хүн байж чадна. Тэрбээр амгалан байдлаа ямагт хадгалж, төлөв даруу хэвээрээ үлддэг билээ.

4. Бүх үгийг эсрэг тэсрэг утга илэрхийлдгээр нь таван зүйлд хувааж болно. Үүнд: зохистой болон зохисгүй, бодит байдалд нийцэх ба үл нийцэх,

Гэгээрэх зам

зөөлөн болон хатуу ашигтай ба хортой, мөн хайрлаж хэлэх болон үзэн ядаж хэлэх үгс ормой.

Танд хандаж эдгээр үгийн алий нь ч хэлсэн, сэтгэлийн тэнцвэрээ хадгалж бүдүүлэг үг үл хэрэглэж, хүмүүст санаа тавьж халамжлан, энэрлийг үзүүлж, уур уцаар, үзэн ядах сэтгэлийг огт мэддэггүй болох хэрэгтэй.

Хэн нэгэн нь хүрз зээтүү хоёроор ээлжлэн газар ухаж, шороогоо алга болгоно гэж эргэн тойрон тараан цацахдаа яаж ч хичээсэн, яаж ч хүссэн шороо алга болж устахгүй бүлгээ. Үүнтэй адил үгсийг устгаж, алга болгож болохгүй.

Иймээс танд хандаж ямар ч үг хэлсэн өөрийгөө төгс болгож, энэрэнгүй сэтгэлээ хөхүүлэн дэмжиж, хичнээн хичээгээд будгаар тэнгэр дээр юм зурж болдоггүйн адил, үгс санаа сэтгэлд чинь ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүйн тулд сэтгэлийнхээ тэнцвэрийг хадгалах хэрэгтэй. Хичнээн ч хичээгээд хуурай өвсөн бамбар асаан их устай голыг хатааж ширгээж болохгүй билээ. Хичнээн оролдоод сайн элдүүртэй арьсыг үрж шар шархийх чимээ гаргаж болохгүй билээ.

Хүн сэтгэлээ дэлхий ертөнц лүгээ адил уужимхан, тэнгэр лүгээ адил зах хязгааргүй, далай тэнгис лүгээ

адил гүн гүнзгий, сайн элдүүртэй арьс лүгээ адил зөөлөн байлгахыг эрмэлзэх хэрэгтэй.

Дайсны гарт орж, зэрлэгээр тамлуулсан ч санаа сэтгэлээр унаж болохгүй. Хэрэв санаа сэтгэлээр унавал, Бурхан багшийн сургаалыг үнэн зөв дагахгүй байна гэсэн үг юм. Ямар ч тохиолдолд сэтгэлээ амгалан хэвээр хадгалж, үзэн ядсан уур хилэнд автсан үг хэлэхийг цээрлэж, хүнд нинжин сэтгэл, хайр халамжаар хандах хэрэгтэй.

5. Нэг хүн үдэш болоход утаа суунагладаг, өдөр нь галд автдаг шоргоолжны үүрийг олж харжээ. Тэрбээр энэ тухайгаа номч мэргэнд хэлсэн аж. Цаадах нь түүнд "Илд авч шоргоолжны үүрийг ухахыг" тушаав. Хүн тушаасан ёсоор нь болгов.

Тэрбээр шоргоолжны үүрийг төнхөж эхлээд оньс, дараа нь хөөс, сэрээ, хайрцаг, яст мэлхий, хутга, хэрчим мах ухаж гаргаж ирэв. Хамгийн сүүлд луу гаргаж ирэв.

Хүн шоргоолжны үүрээс юу олсноо мэргэн хүнд хэлбэл цаадах нь: "Луунаас бусдыг хаях хэрэгтэй. Луунд саад болох хэрэггүй, орхи" хэмээв.

Энэхүү домог үлгэрт "Шоргоолжны үүр" нь хүний биеийг төлөөлнө. "Үдэш болоход утаа

Гэгээрэх зам

суунагладаг" хэмээх нь хүн үдэш болоход өдрийн хэрэг явдлаа дурсаж, сайныг хийсэн байвал баярлан баясч, мууг хийсэн бол харамсан гунихыг хэлж буй юм. "Өдөр галд автдаг" хэмээх нь хүн үдэш бодсоноо өдөр үг, үйлээрээ хэрэгжүүлэхийг хэлж байгаа юм.

Энэхүү домог үлгэрийн "хүн" нь Бурхан багшийн сургаалыг дагаж байгаа юм. "Номч мэргэн хүн" нь Бурхан багш билээ. "Илд" нь ариун тунгалаг оюун ухаан, "гүнзгий ухах" гэдэг нь төгс төгөлдөр болохыг хичээх гэсэн үг билээ.

"Онъс" нь мунхагийн харанхуй, "Хөөс" нь уур уцаар болоод зовлон зүдүүр, "Сэрээ" нь эргэлзэх, түгших, "Хайрцаг" нь шунал хүсэл, үзэн ядах, залхуурах, санаа сэтгэл түгших, харамсах, тээнэгэлзэхийг тус тус хэлнэ. "Яст мэлхий" бол бие, сэтгэл юм. "Хутга" бол таван хүсэл билээ. "Хэрчим мах" нь зугаа цэнгэлд автахын хүслэн юм, эдгээр нь хүний биеийг хордуулах учир энэ бүхнээс ангижрах хэрэгтэй.

Шоргоолжны үүрнээс хамгийн сүүлд гарч ирсэн "Луу" бол хорвоо ертөнцийн шунал тачаалаас салж чадсан санаа сэтгэл юм. Хэрэв хөл доорхи газраа сайн ухвал эцсийн эцэст лууг гаргаж ирнэ гэсэн үг.

"Луунд саад болох хэрэггүй, орхи" гэдэг нь

хорвоогийн шунал тачаалаас ангижирсан сэтгэлийг амгалан байлгаж эхэлсэн хэргээ дуусгах бололцоо олгохыг хэлж байгаа юм.

6. Бүхнийг айлдагч багшийн шавь Пиндола гэгээрснийхээ дараа төрсөн балгас Каусамбидаа эргэж очоод, халуун дотно хандсан оршин суугчдад талархсанаа илэрхийлэхийг хүсчээ. Тэрбээр Бурханы үрийг суулгах газар олохоор шийджээ. Хотын захад цаад зах нь харагдахгүй, цувуулан тарьсан дал модны гудам бүхий цэцэрлэг байв. Хоёр эрэг дээгүүрээ халин урсаж буй Ганга мөрнөөс сэрүүн салхи сэвэлзэнэ.

Нэг удаа зуны халуунд Пиндола шатаам хурц нарны туяанаас заилсхий, дал модны сүүдэрт бясалгал үйлджээ. Яг энэ өдөр Удаяна хаан хатадтайгаа хамт цэцэрлэгт цэнгэхээр ирэв. Тэрбээр хөгжмийн ая, наргиан наадмын шуугианаас цуцаж, модны сүүдэрт зүүрмэглэжээ.

Хааныг унтаж байх хооронд хатад нь цэцэрлэгээр зугаалж байгаад дал модны сүүдэрт бясалгал үйлдэж байсан Пиндолаг олж харжээ. Пиндолаг харж гайхаж биширсэн эмэгтэйчүүд Бурхан багшийн сургаалыг сонирхож, түүнээс ном номлохыг хүсчээ.

Гэгээрэх зам

Хаан сэрээд гав ганцаар хоцорсноо мэдэв. Тэрбээр хатадаа хайж, дал модны сүүдэрт ариун явдалтай даяанч хатдынх нь дунд сууж буйг олж харав. Санаа сэтгэл нь мэдрэхийн зугаа цэнгэлд эвдэрсэн хааны зүрхэнд хардахын гал дүрэлзэн бадарч, уур уцаартаа шатаж, ариун явдалтай даяанч руу дайран давшилж хэлсэн нь: "Чи миний хатдыг уруу татаж байгаадаа ичихгүй байна уу?" Пиндола нүдээ аньж, нэг хэсэг дуугүй суув. Тэрбээр хариуд нь юу ч хэлсэнгүй.

Ариун явдалтны ийм амгалан тайван, хэнэггүй байдлыг харж галзууртлаа уурласан хаан илдээ хуйнаас нь суга татаж, Пиндолагийн нүүрэнд тулгахад цаадах нь үг эс дуугаран, чулуу лугаа адил үл хөдлөн суусаар байлаа.

Уур уцаартаа үнэхээр галзуурсан хаан шоргоолжны үүрийг ухаж, үл хөдлөн сууж байсан хуврагыг улаан шоргоолжоор цацав. Гэвч Пиндола урьдын адил хөдлөлгүй суусан хэвээр.

Тэгтэл гэнэт хаан гэмшин ичиж, ариун явдалт мэргэн хүнээс уучилж өршөөхийг хүсчээ. Тэр цагаас хойш Бурхан багшийн сургаал хааны ордонд түгэн дэлгэрч, удалгүй улс даяар таржээ.

7. Хэд хоногийн дараа Удаяна хаан ойд байсан

Пиндолаг эргэн очиж өөрийнх нь амгалан тайван байдлыг алдуулсан олон асуултын хариуг сонсохыг хүсэв.

"Ариун багштан минь, Бурхан багшийн шавь нар залуухан мөртлөө яагаад уруу татагддаггүй цэвэр ариун хэвээр үлдэж чаддаг юм бэ?" гэв.

Пиндола: "Хаан минь, Бурхан багш бидэнд хүүхнүүдэд хэрхэн хандахыг зааж сургасан юм. Хижээл насны эмэгтэйчүүдийг ээжийгээ, дунд насныхыг дүү нараа, залуухныг нь охидоо хэмээн бодох хэрэгтэй. Бурхан багшийн энэхүү сургаалын ачаар Түүний шавь нар залуу ч гэсэн элдвээр уруу татагддаггүй, цэвэр ариун хэвээр үлддэг билээ" гэв.

"Гэтэл хүмүүс эх шигээ хижээл насны, дүү нар шигээ дунд насны, охид шигээ залуухан эмэгтэйг харж дур хүсэлдээ автан уруу татагддаг шүү дээ. Ариун явдалтай багш минь, Бурхан багшийн шавь нар яаж ийм хүслээ дарж чаддагийг хэлээд өгөөч?" гэж Удаяна хүсэв.

"Хаан минь, Чадагчийн эрхт багш бидэнд хүний биеийг бузартуулдаг цус, идээ, хөлс, тос зэргийг олж харахыг зааж сургасан юм. Хүнд буй энэ бүхнийг олж харснаар бид залуу ч гэсэн сэтгэлээ цэвэр ариун хэвээр хадгалж чаддаг юм" гэж Пиндола өчив.

Гэгээрэх зам

"Ариун багштан минь. Бие бялдар, санаа сэтгэлийн зовлонг давж туулсан, ухаант шавь нарт энэ нь амархан буйзаа. Харин Бурхан багшийн туршлага муутай шавь нарт энэ нь хэцүү биз ээ. Тэд бузартсаныг олж харахыг хүсч тэмүүлэхдээ өөрсдөө мэдэлгүй цэвэр ариунд хэт дурлан шунадаг бий. Бузар булайг олж харахыг тэмүүлэхдээ өөрсдөө мэдэлгүй гоо сайханд дурлан шунах бий. Бурхан багшийн шавь нар гоо сайхан, цэвэр ариун үйл хэргээ үргэлжлүүлэн бүтээхийн бололцоогоо хадгалах өөр янз бүрийн нууц байдаг уу?" гэж Удаяна асуув.

"Хаан минь, Бурхан багш бидэнд таван мэдрэхүйн үүд хаалгыг сайтар хамгаалахыг зааж сургадаг. Нүд өнгө, хэлбэрийг харж, чих хоолойноос гарах дуу авиаг сонсч, хамар анхилууныг үнэртэж, хэл бал бурмыг амталж, бие аятай таатайг мэдэрч байхад Бурхан багш ачтай таатайд уруу эс татагдаж, аягүй таагүй юманд эс уурлахыг зааж сургадаг. Таван мэдрэхүйн цонх хаалгыг сайтар харуулдаж хамгаалж байх хэрэгтэй. Бурхан багшийн энэхүү сургаалын ачаар залуухан шавь нар нь хүртэл санаа сэтгэлээ цэвэр ариун хадгалж чаддаг юм" гэж Пиндола мэргэн айлдав.

"Ариун багштан минь, Бурхан багшийн сургаал номлол үнэн ээв билээ. Би үүнийг өөрийн туршлагаас мэднэ. Хэрэв таван мэдрэхүйн үүд

хаалгыг эс хамгаалвал хүн дорхноо доод хүслийн эрхэнд орно. Бидний үйл хэрэг ариун нандин байхын тулд таван мэдрэхүйн үүд хаалгыг сайтар хамгаалах ёстой" гэж Удаяна өчив.

8. Хүн санаа бодлоо, үйл хэрэг болгож эхлэхэд зайлшгүй сөргөлдөөн буй болно. Хэрэв харааж загнавал хариуд мөн тэгэхийг эрмэлзэнэ. Хүн ийнхүү сөргөлдөхөөс бүхий л аргаар түдгэлзэх хэрэгтэй. Сөргөлдөх нь салхины өөдөөс нулимахтай адил. Энэ нь өрөөлд бус өөрт хор хүргэнэ. Энэ нь салхины эсрэг хог шүүрдэх лүгээ адил. Ингэснээр өөрийгөө л тоос шороогоор булна. Эсрэг үйлдэл зайлшгүй гай гамшиг авчирна.

9. Хүн ховдог харамч сэтгэлээсээ салж өглөгч болох нь тун сайн. Түүнээс гадна бас гэгээрэхийг эрмэлзэж, Бурхан багшийн сургаалыг хүндэтгэн биширвэл бүр сайн.

Хүн хувийн ашиг сонирхолыг үл дээдлэн, бусдад эрвийх дэрвийхээрээ туслахыг хичээх ёстой. Хэрэв өрөөлд тусалвал бусад хүн энэ үлгэрийг дагах билээ. Ингэж зол жаргал бүтэж буй болно.

Дүрэлзэж буй бамбарын галаас хэдэн мянган хүн бамбараа асаасан ч тэр нь үл дуусна. Зол жаргал үүнтэй адил билээ. Бусдад яаж ч харамгүй тараасан

Гэгээрэх зам

тэр нь ширгэж үл дуусна.

Гэгээрэх зам мөрийг дагасан хүн алхам бүртээ туйлын сонор соргог байх ёстой. Зорилго хичнээн өндөр байлаа ч, түүнд алхам алхмаар л ойртоно. Энэ зам мөр өдөр тутмын амьдрал дундуур дайран өнгөрөхийг мартаж үл болно.

10. Гэгээрэх зам мөрийг дагасан хүнд биелүүлэхэд бэрх 20 зүйл буй. Үүнд:

1. Ядуу хүн өглөгч болох бэрх.
2. Бардам хүн гэгээрэхийн зам мөрийг хөөх бэрх.
3. Өөрийгөө умартаж гэгээрэх бэрх.
4. Бурхан багш энэ ертөнцөд байгаа цагт мэндлэх бэрх.
5. Бурхан багшийн сургаалыг сонсох бэрх.
6. Сэтгэлээ ариусгаж доорд хүсэл шуналаас салах бэрх.
7. Гоё сайхан, аятай таатай юмыг үл хүсэх бэрх.
8. Эрх дархтан хүсэл юугаа хангахын тулд эрх дархаа үл хэрэглэх бэрх.
9. Доромжилж байхад гэвчиж, уурлахгүй байх бэрх.
10. Юу ч болсон амар тайван байх бэрх.
11. Аливаа юмыг өргөн цар хүрээтэй, гүн гүнзгий судлах бэрх.
12. Ямар нэгэн юмыг шинээр эхэлж буй хүнийг дооглохгүй байх бэрх.
13. Бардам зангаа барьж дийлэх бэрх.
14. Сайн найзтай болох бэрх.
15. Бурхан багшийн сургаалыг дагаж гэгээрэх бэрх.
16. Гадаад нөхцөл байдлын нөлөөнд орохгүй байх бэрх.
17. Бусдын авьяас чадварыг тааж зааж сургах бэрх.
- 18.

Санаа сэтгэлээ ямагт амгалан байлгах бэрх. 19. Зөв, буруугийн тухай маргахгүй байх бэрх. 20 Зөв арга барилыг сурах бэрх.

11. Муу, сайн хүмүүс зан чанараараа ялгарна. Муу хүн нүгэлийг эс ухаарч, түүнийг үйлдэхээ зогсоож эс чадна Тэрбээр нүглийнх нь тухай хэлэхэд дургүйцэнэ. Сайн хүн буян, нүглийн тухай ойлголттой болой. Тэрбээр нүглийг танимагц, үйлдэхээ зогсоож, нүдийг нь нээж өгсөн хүнд талархан баярладаг. Ийнхүү сайн хүн муугаасаа ялгарна.

Найр тавьж тусалсан хүндээ талархаж эс чадах хүнийг мунхаг гэнэ Ухаантай хүн ямагт баярлаж талархахдаа бэлэн байдаг. Тэрбээр өөрт нь найр тавьж тусалсанд төдийгүй, хүний төлөө халамж анхаарал тавьсан бусад хүмүүст ч ямагт талархан баярлахад бэлэн байдаг.

III

БУРХАН БАГШИЙН СУРГААЛЫГ ЭРТНИЙ ДОМОГТ ӨГҮҮЛСЭН НЬ

1. Эрт урьд цагт хөгшчүүлээсээ салахын түүс болсон улс байжээ. Тэр улсад насан өндөр хэнийг ч алс холын ууланд аваачиж орхидог аж. Гэвч нэг сайд

Гэгээрэх зам

хөгшин эцгээсээ салж чадахгүй байжээ. Тэрбээр гүнзгий том нүх ухаж, доторхийг нь янзлан тохижуулж тэнд эцгээ нуусан аж.

Нэг удаа бурхан, тэнгэрээс морилон заларч, эзэн хаанд хүнд хэцүү асуулт тавьжээ: "Энэ хоёр могойг хараад аль нь эр, аль нь эм болохыг ялгаж хэл. Эс таавал улс гүрнийг чинь хүйс тэмтрэнэ" гэхэд хаан эр, эм могойг ялгаж чадсангүй. Ордныхон дотроос ч ялгаж хэлэх хүн олдсонгүй. Эзэн хаан, улс гүрэн даяараа зарлиг буулгаж, эр, эм могойг ялгаж хэлсэн хүнд их шан амлав.

Хаанд бурханы хэлсэн оньсогын тухай сайд эцэгтээ хэлжээ. "Энэ амархан шүү дээ. Хоёр могойг зөөлөн олбог дээр тавибал мушгиралдан цагираглах нь эр могой, үл хөдлөн хэвтэх нь эм могой" хэмээн эцэг нь заажээ.

Сайд нь эр, эм могойг хэрхэн ялгах тухай хаандаа хэлсэн аж. Ийнхүү тэр оньсогыг тайлжээ. Бурхан урьд өмнөхөөсөө улам ээдрээтэй хэцүү оньсого таалгаж эхлэв. Хаан болоод ордныхон нь тэдгээр оньсогыг тааж чадахгүй байлаа. Харин мэргэн эцгийнхээ ачаар өнөөх сайд, оньсого бүгдийг тайлжээ.

Асуусан асуулт, хариулсан хариуг доор

сийрүүлэв.

"Унтаж байхад нь сэрүүн, сэрүүн байхад нь унтаж байна хэмээн хэний тухай ярьдаг вэ?"

"Гэгээрэх зам мөрийг даган явж буй хүний тухай ингэж ярьдаг. Энэхүү зам мөрийн тухай мэдэхгүй учир нойрсож буй хүнийг сэрүүн байна гэдэг. Харин энэ зам мөрийг мэддэг учир сэрүүн байгаа хүнийг нойрсож байна гэдэг". "Аварга том зааны жинг яаж мэдвэл зохих вэ?". "Зааныг завинд суулгаж, завь усанд хэр зэрэг суусныг тэмдэглэж, дараа нь завинаас буулгаж, оронд нь ус тавьсан тэмдэгт хүртэл завинд чулуу ачвал зохино. Эцэст нь ачсан чулуугаа жигнэвэл зааны жинг мэдэж болно".

"Нэг аяга ус их тэнгисээс илүү гэдэг чухамхүү юу гэсэн үг вэ?", "Хэрэв ариун цагаан сэтгэлд хөтлөгдөн аягаар ус хутгаж буурал эцэг, эхдээ юм уу, эсвэл өвдөж зовсон хүмүүст уулгавал энэ сайн үйл хэзээ ч үл мартагдана. Өргөн их тэнгист хичнээн их ус байлаа ч нэгэн өдөр ширгэж болно. Харин буян хэзээ ч ширгэж алга болдоггүй. Тиймээс аяга ус их тэнгисээс илүү гэж ярьдаг юм".

Бурхан яс арьс болсон туранхай хүнийг дуудан ирүүлжээ. Туранхай хүн асуусан нь: "Энэ ертөнцөд надаас илүү өлсч буй хүн бий юу?" "Бий. Хэрэв хүн

Гэгээрэх зам

зүрх сэтгэл цэвдэг, санаа бодол ядуу, лам, бурхан ном хэмээх гурван эрдэнэд үл итгэдэг бол сэтгэл нь өлсөж цангахаас гадна, хойт ертөнцөд шийтгэл хүлээж бирд буюу өлсгөлөн сүнс болж урт удаан хугацаанд дааж давшгүй тамын зовлон амсана".

"Энэ зандан модоор хийсэн дөрвөлжин хэлбэртэй самбар байна. Энэ самбарын аль хэсэг нь уг модныхоо үндсэнд ойр вэ?" "Энэ самбарыг усанд талбихад арай гүн живж буй тал нь үндсэндээ ойр нь юм".

"Хоорондоо яг адилхан хоёр хүлэг байна. Нэг нь эх, нөгөө нь унага юм. Яаж ялгах вэ?" "Хоёуланд нь өвс тавьж өг! Эх нь үрдээ өвсний сайныг өгдөг юм. Ингэж тэр хоёрыг амархан ялгаж болно".

Эдгээр асуултын хариуг сонссон бурхан магнай тэнийн баярлав. Хааны магнай мөн адил тэнийжээ. Хаан, сайдынх нь нүхэнд нуугдсан эцэг ийнхүү цэцэн мэргэн хариулсныг мэдээд зарлиг буулгаж, өвгөдөө тээршаан зайлуулахыг хориглож, харин хүндэлж дээдлэхийг тушаав.

2. Энэтхэгийн Видеха хэмээх улсад хатан хаан зүүдэндээ зургаан соёотой цагаан заан үзжээ. Тэрбээр хаанаас цагаан зааны зургаан соёог олж бэлэглэхийг гуйжээ. Хатандаа ухаангүй хайртай хаан, энэхүү хүсэлтийг зөвшөөрөхөөс өөр аргагүй болов.

Тэрбээр мөнөөх заан хаана нутагладгийг мэдэх хүнд үлэмж их шагнал, бэлэг сэлт өгөхийг амлаж, улс даяар зар түгээв.

Тэр цагаан заан алс хол, Хималайн уулсад амьдардаг байжээ. Тэрбээр Бурхан багшийн хутгийг олохоор бэлдэж байлаа. Нэг удаа тэрбээр анчин эрийн амийг аварчээ. Эх нутагтаа эргэж ирсэн мөнөөх анчин хааны зарлигийг сонсч зааны нутагладаг газрыг мэддэг хүнд ихээхэн шагнал хүртээхийг дуулаад өөрийнхөө амийг аварсан зааныг алж, соёог нь авахаар явжээ. Мөнөөх заан Бурхан багшийн хутгийг олох гэж бэлдэж байсныг нүгэлт гөрөөчин мэдэх тул зааныг хуурахаар орхимж нөмөрч ламын дүрээр очжээ. Тэгээд заан өчүүхэн бээр сэжиглэлгүй амарч байхад нь хортой сумаар харважээ.

Шархадсан заан үхэл нь ирснийг мэдэрчээ. Гэвч өөрөөс нь урваж тэрсэлсэн анчинд уурлаж унтууцсангүй. Харин хорвоогийн шунал тачаалын эрхэнд орсон түүнийг өрөвдөж, муу зальтай анчныг хэдэн хэсэг болгон урж тасдахыг завдан, уурлаж хилэгнэсэн нөхдөөс нь хамгаалж, өөрийнхөө доор оруулан нууж, хөлөөрөө хамгаалсан аж. Заан анчнаас юуны учир амийг нь хөнөөж буйг асууж, соёо нь хэрэг болсныг мэдмэгц соёогоо том модонд цохиж хугалаад анчинд өгчээ. "Ингээд миний зовлон зүдүүр

Гэгээрэх зам

дуусав. Одоо би бээр Бурхан багшийн ертөнцөд мэндэлнэ. Би Бурхан багш болмогцоо юуны түрүүн чиний зүрхнээс шунал хүсэл, уур хилэн, харанхуй мунхаг хэмээх хорт гурван сумыг суга татан хаяна" хэмээн цагаан заан тангараг тавьжээ.

3. Хималайн уулын бэлд, хулсны ширэнгэнд бусад шувууд, амьтантай хамт нэгэн тоть амьдарч байжээ. Нэгэнтээ хүчтэй салхи босч хулс моддын гол хоорондоо хавиралдсанаас болж гал гарчээ. Салхи хүчтэй үлээж, ширэнгэ тэр аяараа галд автаж, түймэр дүрэлзэв. Их галд шахагдаж түрэгдсэн ан амьтан, жигүүртэн шувууд чарлах нь чарлаж, хашгирах нь хашгирна. Тоть шувуу урт удаан хугацааны турш өөрийг нь орогнуулсан хулсан ширэнгэнд баярлан талархсанаа илэрхийлж шувууд амьтдыг аврахын тулд холгүй бус цөөрөм рүү нисч усанд нь умбаж, жигүүрээ норгон, буцаад агаарт хөөрч түймэрт автсан ширэнгэний дээрээс далавчаа сэгсэрч ус цацав. Хулсан ширэнгэд баярлаж талархсан, мөн шувууд, амьтдыг өрөвдөн хайрласан тоть ядарч цуцахыг үл мэдэн нуур, ширэнгэ хоёрын хооронд ниссээр байлаа.

Тоть шувууны бусдын тусын тулд өөрийгөө умартах сэтгэлийн тэнхээ, нигүүлсэнгүй сэтгэл нь тэнгэрт буй Бурханы гайхал бишрэлийг төрүүлжээ. Тэрбээр тэнгэрээс залран ирж, тоть шувуунаас

асуусан нь: "Би чиний халуун сэтгэлийн хүсэл тэмүүллийг ойлгож байна Гэхдээ чи яаж хэдхэн дусал усаар түймэр унтраана гэж бодно вэ?" Тоть хариулсан нь:

"Би талархаж баярласан, нигүүлсэнгүй сэтгэлдээ хөтлөгдсөн юм. Тиймээс надад бүтэхгүй чадахгүй юм байхгүй. Би энэ түймрийг унтраах ёстой. Үхсэн ч хамаагүй энэ галыг л унтраана" гэв.

Ийм хариу сонссон Бурхан хайлж тоть шувуунд туслан хамтын хүчээр түймрийг даржээ.

4. Хималайн ууланд хоёр толгойтой шувуу амьдарч байжээ.

Нэг толгой нь нөгөө толгойгоо амтат жимс зооглож буйг үзээд атаархахдаа хортой жимс идэхээр шийдэв. Чингээд хортой жимсээ ч идэв, хоёулаа ч үхэв.

5. Нэг могойн сүүл нь толгойтойгоо маргалджээ.

"Толгой, чи дандаа түрүүлж явдаг. Ингэх нь шударга бус. Би ч гэсэн түрүүлж явж байя".

Толгой хариулсан нь: "Би үргэлж түрүүлж явдаг нь үнэн. Анхнаасаа ингээд бүтчихсэн болохоор яая

Гэгээрэх зам

гэхэв дээ. Би чамайг урдаа оруулж чадахгүй".

Тэр хоёр удтал маргалдаж, хичнээн сөргөлдсөн ч толгой ямагт түрүүлэн явдаг байлаа. Чингээд уурласан сүүл нь толгойгоо явуулахгүйн тулд модны голыг ороожээ. Толгой гайхаш алдран зогсоход сүүл нь амжиж ороосон модноосоо салж урагшаа мөлхөөд удалгүй галтай нүх рүү унаж шатаж үхэв.

Юм бүхэн өөрийн гэсэн байртай, бас тусдаа үүрэгтэй билээ. Хэрэв байр сууриа голж, ногдсон үүргээсээ татгалзвал өөрийгөө ч, бусдыг ч хөнөөнө.

6. Дүрсхийдэг зантай нэгэн эр байжээ. Нэг удаа байшингийн нь дэргэд хоёр хүн ярилцаж байв.

"Уг нь энэ байшингийн эзэн сайн хүн байгаа юм. Ганц гэм нь дүрсхийдэг зантай" гэлцэв.

Үүнийг сонссон нөгөө эр дүрсхийн уурлаж, гэрээсээ харайн гарч ирээд ярилцаж байсан хоёрыг дайрч цус нөжийг нь гартал зоджээ.

Ухаантай хүний гэм бурууг хэлэхэд түүнийгээ засахыг эрмэлзэнэ. Тэнэг хүнд алдааг нь хэлбэл засаж залахын оронд улам том алдаа гаргадаг.

7. Нэг их баян, тэнэг хүн байжээ. Тэрбээр өндөр шовх, гоё оройтой гурван давхар байшинг харчихаад түүнтэй ижил байшин барихаар шийджээ.

Тэрбээр мужаан дуудаж, өндөр оройтой байшин барихыг тушаав. Захиасыг биелүүлж ажлаа эхэлсэн мужаан байшингийн суурь тавьж, дараа нь хоёрдугаар давхрыг барьж дуусаад, гуравдугаар давхраа эхэлжээ. Мужааны ажиллахыг харсан баян тэвчээр алдан:

"Надад байшингийн суурь, хоёрдугаар давхарын аль нь ч хэрэггүй. Гуравдугаар давхрын өндөр орой л хэрэгтэй. Түүнийг л шалавхан бариад өг" гэв.

Тэнэг хүн хөдөлмөр гэдгийг үл мэднэ, гагцхүү санаанд нь нийцэх бэлэн юм л шаардана. Гэтэл суурь тавилгүй гуравдугаар давхрыг барьж болохгүйтэй адил, сайн хөдөлмөрлөхгүй бол бэлэн юм хаанаас гарах вэ?

8. Нэг хүн зөгийн бал чанаж байхад найз нь иржээ. Тэрбээр анд нөхрөө амтат балаар дайлах гэж балаа гал дээрээсээ авалгүй дэвүүрээр сэвж хөргөж эхлэв. Үүнтэй адил ертөнцийн шунал тачаалын галыг унтраалгүйгээр сэрүүн тунгалаг гэгээрэлд хүрч үл болно.

Гэгээрэх зам

9. Хоёр чөтгөр нэг хайрцаг, нэг таяг, хос шаахайг хувааж чадахгүй маргалдав. Тэд бүтэн өдрийн турш хэн нь юу авах тухай маргалдаад шийдэж чадсангүй.

Нэг хүн тэднийг харчихаад асуусан нь:

"Та нар юунд ингэж их маргалдана вэ? Энэ чинь ямар юм болоод та хоёр тэгтлээ маргалдаж хувааж чадахгүй байгаа юм бэ?" гэв.

Чөтгөрүүд хариулсан нь: "Энэ хайрцагаас хоол унд, үнэт эрдэнийн чулуу гээд юу хүссэнээ авч, энэ таягаар ямар ч дайсныг дарж, энэ гутлыг өмсвөл агаарт дүүлэн нисч болно" гэв.

Нөгөө хүн хэлсэн нь:

"Та хоёр маргалдах юм алга байна шүү дээ. Гэдрэгээ жаахан ухраад зогсч бай. Би та нарт тэнцүүхэн хуваагаад өгье" гэв.

Чөтгөрүүд өөрөөс нь холдмогц хайрцаг, таягийг авч, хоёр шаахайг нь хөлдөө угласан нөгөө хүн агаарт дүүлэн нисч бараа сураггүй болов.

Энэ домог үлгэрт чөтгөрүүд нь буруу шашинтан, хайрцаг бол өглөг гэсэн үг юм. Тэд өглөгөөс элдэв үнэт эрдэнэ буй болдгийг үл мэднэ.

Таяг нь сэтгэлээ төвлөрүүлэхийг хэлж буй. Тэд сэтгэлээ төвлөрүүлж, ертөнцийн шунал тачаалын шулмыг дарж болохыг үл мэднэ.

Хос шаахай нь ариун ном сургаалыг хэлж буй юм. Энэхүү ариун номын ачаар аливаа маргааныг шийдэж болохыг тэд үл мэднэ. Иймээс хоорондоо маргалдаж, хайрцаг, таяг, хос шаахай гурвыг хувааж үл чаджээ.

10. Нэг үдэш аянчин эр эзгүй хоосон байшинд буудаллажээ. Гэнэт шөнө дунд чөтгөр хүрч ирэв. Тэрбээр үхсэн хүний хүүр авчраад шалан дээр чулууджээ.

Удалгүй бас нэг чөтгөр ирж: "Энэ бол миний олсон хүүр" хэмээжээ. Хоёр чөтгөр хоорондоо маргалдаж эхлэв.

Тэгснээ эхний чөтгөр нөгөөдөө:

"Ингэвээс бидний хэн нь ч юм олж үл долооно. Ерөөсөө гэрч авчирч, хэний олсон хүүр болохыг хэлүүлье" гэв.

Нөгөө чөтгөр нь зөвшөөрчээ. Эхний чөтгөр нь энэ бүх хэрэг явдлыг харж, үнхэлцгээ хагартал айж байшингийн буланд шигдсэн нөгөө хүнийг гаргаж

Гэгээрэх зам

ирээд "Хэн анх хүүр авчирсныг хэл" гэж тушаав.

Айж чичирсэн хүн өөрийгөө хаашаа ч гарах аргагүй болсныг ухаарчээ. Хэрэв тэрбээр хоёр чөтгөрийн нэгийг нь дэмжиж, нөгөөг нь гомдоовол зайлшгүй алуулна. Яасан ч үхлийн аюулаас мултрах аргагүйгээ ухаарч, зориг орсон эр санаа шулуудаж, яг харснаа хэлжээ.

Хоёр дахь чөтгөр яг л бодсоноор нь хилэгнэж, өрөөсөн гарыг нь тас татан хаяжээ. Эхний чөтгөр үхсэн хүний гарыг авч, тасарсан гарынх нь оронд тогтоов. Улам уурсан хоёр дахь чөтгөр нөгөө гар, хоёр хөлийг нь таслаж, түүгээр ч зогсохгүй бие, толгойг нь тасджээ. Эхний чөтгөр бүгдийг нь үхсэн хүний эрхтнээр сольж орлуулжээ.

Хоёр чөтгөр хоорондоо цуцаж ядартлаа маргаад тэр өрөөнд энд тэнд хэвтэж буй хүний гар, хөл, бусад эрхтнүүдийг идчихээд ам хамраа арчсаар арилаад өгчээ.

Аянчин ганцаархнаа хоосон байшинд үлдэв. Түүний хоёр гар, хөл, бие, толгой, ер нь эцэг эхээс заяасан бүх эрхтнийг хоёр чөтгөр идэж, оронд нь огт танихгүй хүний эрхтэнтэй болгожээ. Ингээд аянчин өөрийгөө би мөн үү, эсвэл би бус уу хэмээн ялгаж ухаарахаа больжээ. Үүрээр элий балай хүн лүгээ

адил аймшигт шөнийг өнгөрөөсөн байшингаасаа гарч явлаа. Замд нь сүм тааралдсанд баярлаж, тэнд ороод урьд шөнө өөртэй нь тохиолдсон явдлыг нэгд нэгэнгүй ярьж хэрхэхийг асуужээ. Хүмүүс аянчны ярьсныг сонсчихоод өөрийн "би" үл орших үнэнийг ухаарч баярлан баясчээ.

11. Гоё сайхан хувцастай, гоо үзэсгэлэнтэй хүүхэн нэг байшинд хүрэлцэн иржээ. Гайхаш алдсан эзэн асуусан нь: "Та хэн буй?" Хүүхэн хариулсан нь: "Би бээр хүмүүст зол жаргал авчирагч жаргалын бурхан". Эзэн баярлаж, зочныг гэртээ саатахыг урьж, хүндэтгэн дайлав.

Удалгүй өөр нэгэн эмэгтэй хүрч ирэв. Өмссөн хувцас нь ядуу зүдүү, өнгө зүс нь аймаар муухай аж. Хэн болохыг нь эзэн асуув. Цаадах нь, би бээр гачигдал зовлонгийн бурхан гэв. Мэл гайхсан эзэн түүнийг хөөн зайлуулах гэжээ. Гэтэл гачигдал зовлонгийн бурхан хэлсэн нь:

"Жаргалын бурхан бол миний эгч юм. Бид хоёр эвтэй найртай учраас үргэлж хамт амьдардаг. Хэрэв чи намайг хөөвөл, миний эгч ч гэсэн эндээс яваад өгнө шүү". Гачигдал зовлонгийн бурхан явсны дараа, аз жаргалын үзэсгэлэнт бурхан мөн адил явчив.

Амьдрал буй бол үхэл буй. Зол жаргал буй бол

Гэгээрэх зам

гай зовлон буй. Сайн юм буй бол, муу юм бас буй. Хүмүүс үүнийг мэдэх ёстой. Мунхаг хүн гай зовлонгоос зугтаж, гагцхүү жаргалын хойноос хөөцөлдөнө. Гэгээрэх зам мөрийг дагаж буй хүн эдгээр ойлголтоос давж алинд нь ч гэсэн нэг их дасаж дадах хэрэггүй.

12. Эрт урьд цагт ядуухан зураач амьдарч байжээ. Тэрбээр эхнэрээ орхиж, хөрөнгө мөнгө хураахаар харийн орныг зорив. Гурван жилийн турш борви бохирохгүй хөдөлмөрлөж ихээхэн мөнгө хөрөнгө цуглуулав. Эх нутагтаа харьж явах замдаа бурханы шашны лам нарт өргөл барьц барьж буйтай таарсан зураач магнай тэнийн баярлажээ. "Би одоо болтол ганц ч удаа жаргалын үрийг суулгаж үзээгүй билээ. Харин одоо жаргалын үр суулгах талбайгаа оллоо. Ийм сайхан учралыг алдаж яаж болох вэ?" хэмээн дуу алдаж, хураасан хөрөнгө мөнгөө үл харамлан лам нарт өглөг барьц барихад зориулжээ. Тэрбээр гэртээ гар хоосон буцаж ирсэн аж.

Эр нөхөр нь гар хоосон эргэж ирсэнд эхнэр нь уурлаж, хураасан хөрөнгө мөнгөө хаашаа яаж үрснийг шалгаан байцаав. Нөхөр нь хураасан хөрөнгөө найдвартай агуулахад хадгалсан гэж хариулав. Юун агуулах вэ хэмээсэнд ариун шударга лам хувраг нар хэмээжээ.

Уурлаж уцаарласан эхнэр нь нөхрөө шүүхэд мэдүүлэн бариулж, нөхөр нь байцаагджээ. Тэрбээр хариулсан нь:

"Би борви бохисгүй хөдөлмөрлөөд олсон хөрөнгө мөнгөө дэмий юманд зарж үрээгүй. Би одоо болтол жаргалын үрийг суулгаагүй явсан. Харин түүнийг суулгах шимт хөрстэй талбай болсон буян үйлдэх ёслолтой таараад сүсэглэн итгэж, авч явсан хөрөнгө мөнгөө харамлаж нуулгүй өргөл болгосон бүлгээ. Би бээр жинхэнэ баялаг бол үнэтэй цэнэтэй зүйлс бус харин сэтгэл юм гэдгийг ухаарсан билээ" гэжээ.

Шүүгч зураачийн өчлийг сонсоод тэнд байсан хүмүүстэй нэгэн адил баярлан хөөрч, магтан сайшаажээ. түүнээс хойш зон олон түүнд нийтээрээ итгэдэг болж, тэрбээр баяжиж, эхнэртэйгээ цуг амар сайхандаа жаргажээ.

13. Эрт урьд цагт оршуулгын газраас холгүй нэг хүн амьдарч байлаа. Нэгэн шөнө түүнд өөрийг нь дуудах дуу хүүрийн нүхнээс дуулдахад үнхэлцгээ хагартал айж чичрэв. Үүр цайсан хойно, шөнө болсон явдлыг найз нөхөддөө хэлжээ. Нэг найз нь зоригтой эр байсан тул, дараачийн шөнө хүүрийн нүхнээс дуу гарвал юу байгааг очиж үзэхээр шийджээ.

Гэгээрэх зам

Дараачийн шөнө түрүүчийнхтэй адил дуу гарч, мөнөөх оршуулгын газрын ойролцоо амьдардаг хүнийг дуудсан аж. Цаадах нь энэхүү дууг сонсч айн чичирчээ. Түүний зоригтой найз нь дуулдах дууг чиглэн оршуулгын газар очоод, чимээ гарах газрыг олж, хэн буйг асуужээ.

Газар дороос гарсан дуу хэлсэн нь:

"Би бол газар дор нуусан эрдэнэ юм. Би, нэрийг нь дуудсан тэр хүндээ очих гэсэн ч, тэрбээр айгаад ирээгүй юм. Чи зоригтой хүн тул миний буянд эн тэнцэнэ. Маргааш өглөө би долоон зарцаа дагуулаад танайд очно" гэв.

Зоригтой хүн хэлсэн нь: "За тэгээрэй, би чамайг хүлээж байя. Харин яаж угтвал зохих вэ?"

Нөгөө дуу хариулсан нь: "Танайд лам нарын дүрээр очно. Юуны түрүүн биеэ угааж ариутгаарай. Гэр орноо цэвэрлэж, ус бэлдчихсэн байгаарай. Тэгээд шингэвтэр будаатай найман аяга тавиад хүлээж бай.

Тэр хоолыг идэж дуусмагц биднийг нэг нэгээр нь тусгай өрөөнд оруулаарай. Бид алттай сав болон хувирна" гэв.

Маргааш өглөө нь хэлсэн ёсоор бүх юмыг засч бэлджээ. Зоригт эр угаал үйлдэж, гэр орноо янзалж, зочдоо ирэхийг хүлээжээ. Удалгүй бадар барьсан 8 лам залрав. Тэднийг гэртээ урьж, хоол ус өргөн барьж, дараа нь нэг нэгээр нь бэлдсэн өрөөндөө аваачив. Найман лам алтаар дүүрэн сав болон хувирчээ.

Атаа жөтөө ихтэй нэг хүн үүнийг дуулж мэдээд бас алттай болохыг хүсэв. Тэрбээр мөн адил гэр орноо цэвэрлэн янзалж, найман лам залж, хоол ундаар дайлж, дараа нь мухрынхаа нэг өрөөнд оруулаад түгжив. Гэвч найман лам нь алт болж хувирахыг хүссэнгүй, уурлан хашгиралдаж, атаа жөтөөтэй тэр эрийг шүүхэд мэдүүлэн баривчлуулжээ.

Оршуулгын газрын ойролцоо амьдардаг хулчгар эр бас үнэт эрдэнэс өөрийнх нь нэрийг дуудаж байсныг санав. Тэрбээр мөн адил шунаж, эрдэнэс өөрийнх нь мөн учраас нэрийг нь дуудсан хэмээн боджээ. Тэрбээр найзындаа очиж, алттай савыг авах гэтэл олон могой байжээ. Могой аймхай хүн рүү дайрсан аж.

Энэ явдлын тухай хаан мэджээ. Тэрбээр зоригт эрийг алтны эзэн мөн хэмээв. Ийнхүү зарлиг айлдахдаа хаан номлосон нь: "Ертөнцийн бүх юм

Гэгээрэх зам

үүнтэй адил бүлгээ. Тэнэг хүн ямагт аз дайрахыг л хүлээнэ. Гэтэл аз ганцаараа тохионо гэж үгүй. Энэ нь ном сургаалыг ёс төдий дагадаг, сэтгэлдээ жинхэнэ сүсэг итгэлгүй хүнтэй ижил юм. Тийм хүн сэтгэлийн жинхэнэ амарлингуй байдлыг олохгүй".

II БӨЛӨГ

БОДЬ МӨРИЙН ЗЭРГИЙГ ОЛОХ

АРГА ЗАМ

I

ҮНЭНИЙ ЭРЭЛ

1. Сансар огторгуй яаж бүтсэн, ямар бүтэцтэй вэ? Сансар огторгуй мөнх орших уу? Эсвэл хэзээ нэгэн цагт сөнөж мөхөх үү? Сансар огторгуй эцэс төгсгөлгүй юу? Эсвэл хаа нэгтээ зах хязгаар нь бий юу? Нийгэм яаж бүтсэн, ямар бүтэцтэй вэ? Нийгмийн төгс төгөлдөр ямар хэлбэр байдаг вэ? Эдгээр асуултад хариу авсныхаа дараа л гэгээрэх зам мөрийг дагана гэвэл бүгд түүнээсээ өмнө амьсгал хураана гэсэн үг.

Нэг хүн хорт суманд шархадсан гэж бодъё. Төрөл төрөгсөд, ойр дотны хүмүүс нь цугларч сумыг нь сугалж, шархадсан хүнд тус үзүүлэх хэрэгтэй хэмээн эмч дуудна.

Гэтэл шархадсан хүн ингэж хэлбэл юу болох вэ?

"Та нар азнаж бай, энэ сумыг битгий сугалж ав. Би над руу хэн харвасныг мэдмээр байна. Эрэгтэй хүн үү, эсвэл эмэгтэй хүн үү? Ер нь тэрбээр ямар хүн бэ? Ямар нумаар харвасан бэ? Том уу эсвэл жижигхэн нум уу? Модон уу эсвэл хулсан нум уу? Хөвчийг нь юугаар хийсэн бэ? Шөрмөсөөр үү, эсвэл

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

ороонго ургамлаар уу? Сумыг нь юугаар хийсэн бэ? Модоор уу, эсвэл хулсаар уу? Сумны өд нь ямар вэ? Энэ бүхнийг намайг мэдтэл хүлээж бай, сумыг битгий сугалаарай".

Тэрбээр энэ бүхнийг мэдэхээс өмнө хор бүх биеэр нь тарж, амьсгал хураах нь эргэлзээгүй. Иймд юуны түрүүн сумыг сугалан авч, хорыг биеэр нь тараахгүйн тулд бололцоотой бүхнийг хийх хэрэгтэй.

Сансар огторгуй ямар ч бүтэцтэй байсан, манай нийгмийн төгс төгөлдөр хэлбэр ямар ч байлаа гэсэн, юуны түрүүн бид нарт заналхийлж буй аюулыг зайлуулах хэрэгтэй.

Сансар огторгуй маань мөнх үү, удахгүй мөхөх үү гэдгээс үл шалтгаалан амьдрал, өвчин, үхэл, уй гашуу, уйтгар гуниг, зовлон зүдүүрийн галын аюул бидэнд ямагт заналхийлдэг. Энэ галд автахаас зайлсхийхийн тулд бид гэгээрэх зам мөрийг дагах хэрэгтэй юм.

Бурхан багш хэрэгтэй юмыг л зааж номлодог. Тэрбээр хэрэггүй юмыг зааж номлодоггүй. Тэрбээр хүмүүс мэдэх юмаа л мэдэх, татгалзах юмнаасаа татгалзах, сурах ёстойгоо сурах, гэгээрэх ёстойдоо л гэгээрэх хэрэгтэй хэмээн номлодог.

Тиймээс хүн сонголт хийх ёстой. Тэрбээр өөрт нь хамгийн чухал, хамгийн хэрэгтэй нь юу вэ? гэдгийг шийдэж, өөрийн хамгийн гол асуудлыг шийдвэрлэхэд сэтгэл юугаа бэлдэхээс эхлэх ёстой юм.

2. Модны гол олохоор ой руу явсан хүн навч, мөчир түүчихээд модны голтой боллоо гэж бодвол мунхаг хэрэг болно. Заримдаа модны голтой болохыг хүссэн мөртлөө холтос юм уу, эсвэл доторх хальс, нэг үеийг нь хуулчихаад модны голтой болсон гэж боддог.

Амьдрах, өтлөх, өвдөх, үхэхийн болон уй гашуу, уйтгар гуниг, зовлон зүдүүрийн айдсаас салахын тулд хүн гэгээрэх зам мөрийг хайдаг. Энэ нь тэрхүү модны гол юм. Гэвч зарим нь өчүүхэн нэр хүнд, алдар нэр олчихоод түүндээ сэтгэл ханаж ихэмсэг зан гаргаж, өөрийгөө өргөмжлөн магтаж, бусдыг доромжилж эхэлдэг. Ийм хүмүүс навч, мөчир цуглуулснаа модны голтой боллоо гэж эндүүрдэг.

Өчүүхэн хүч чадал зарцуулчихаад хүссэн бүхнээ биеллээ гэж боддог хүмүүс ч буй. Тэд энүүхэнд сэтгэл ханаж ихэмсэг зантай болж, өөрийгөө өргөмжлөн магтаж, бусдыг дайрч доромжилдог. Ийм хүмүүс гаднах хальсыг нь хуулж авчихаад модны голтой болсон гэж эндүүрдэг.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Аливаа үйл хэргийн үндэс язгуурыг дөнгөж хардаг болчихоод олсон амжилтандаа ханан ташуурч, ихэмсэглэн, өөрийгөө өргөмжлөн магтаж, бусдыг басан доромжилдог хүмүүс буй. Ийм хүмүүс гаднах нэг үеийг нь хуулж авчихаад модны голтой болсон гэж андуурдаг. Эдний аль аль нь хүч чадлаа дайчлахгүй, залхуу хойрго болдог. Тэд дахин дахин зовж зүдэрнэ.

Гэгээрэхийг зорьсон хэн нэгэнд нэр хүнд, алдар гавъяа, өргөл барьц аль нь ч зорилго болж чадахгүй. Өчүүхэн хичээл зүтгэл, санаа сэтгэлийн амгалан байдал, хэрэг явдлын уг үндсийг өнгөц хардаг болох нь зорилго бус юм.

Юуны түрүүн энэ ертөнцөд амьдрал, үхлийн үнэн мөн чанарыг тогтоох шаардлагатай юм.

3. Ертөнц энэ буйгаараа мөн чанаргүй билээ. Сэтгэлдээ элдэв санаархалыг арилгах замыг хайх хэрэгтэй. Төөрөгдөл гадаад нөхцөл байдалд бус харин сэтгэлд төрж буй болдог.

Сэтгэлийн хүсэл хүний зовж зүдэрдэг тэрхүү гай гамшгийн галыг асааж бадраана. Мунхагаас болж төөрөгдлийн харанхуй, сэтгэлийг хучиж хүн уй гашууд автаж, гуньж гутардаг. Чухамхүү энэ сэтгэл л төөрөгдлийн байшин савыг бүтээн буй болгодог.

Гэгээрэхийг хүсч буй хүн энэхүү сэтгэлтэй тэмцэх шаардлагатай.

4. "Сэтгэл минь, чи юунд дэмий юмны эрэлд ийш тийш үсчинэ вэ? Чи юунд түгшин бачимдаж, нэг ч хором амгалан тайван байж үл чадна вэ?"

Чи юунд намайг төөрөгдүүлж, элдвийн эд юмс цуглуулахад хүргэнэ вэ?

Зээтүү газар хүрэхээс өмнө хугарвал, газар хагалж болохгүйтэй адил, хэдийгээр тоо томшгүй олон төрлийг дамжсан боловч би үргэлж төөрөгдлийн далайд хөвж явсан бөгөөд сэтгэлийнхээ атар газрыг хагалж чадаагүй юм.

Сэтгэл минь, чи надад хааны амьдралыг хүртэл заяаж, бас гуйлгачны амьдралыг ч үзүүлж, би гуйлга гуйж ч явлаа.

Чи надад бурхадын ертөнцөд элбэг дэлбэг амьдрах хувь тавилан заяаж, би тэнд цэнгэл жаргалд умбаж явлаа, тамд амьдрах тавилан оноож, би тэнд галд шатаж ч явлаа.

Тэнэг сэтгэл минь чи намайг янз бүрийн зам мөрд уруу татаж байлаа. Одоо болтол би бээр чамайг дуулгавартайяа дагаж, санаа бодлын чинь эсрэг

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

хэзээ ч зүтгэж байгаагүй билээ. Гэвч одоо би бурхан багшийн сургаалыг танин мэдлээ. Одоо чи намайг бүү түгшээж бачимдуул, надад бүү саад бол. Зовлон зүдүүрээс салах, түргэн гэгээрэх бололцоо олго.

Сэтгэл минь, хэрэв чи үнэнийг ухаарч, энэ ертөнцөд аливаа юм өөрийн мөн чанаргүй, бүх юм хувиран урсаж, өөрчлөгддөгийг ойлгож, дасаж дадсанаасаа ангижирч, эд юмсыг өөрийн хэмээн тооцохоо больж, шунал хүсэл, уур хилэн, тэнэг мунхгаасаа салвал амарлингуй байдлыг олно.

Хэрэв чи оюуны илдээр ховдог хомхой сэтгэлийн ургамлыг тас цавчвал, өөрийн хүсэл сонирхолд хөтлөгдөн ашиг хонжоо, нэр төр, алдар хүндийн хойноос хөөцөлдөхөө боливол амар амгаланг олно.

Сэтгэл минь, чи намайг гэгээрэх замд залж авчирсан хэрнээ, яагаад дахин түгшиж бачимдаж, хорвоогийн ашиг сонирхол, алдар нэрийг хөөцөлдөх болов?

Ямар ч барьцгүй, үргэлж яарч урагшаа тэмүүлж байдаг сэтгэл минь, гэтлэхэд бэрх төөрөгдлийн далайг гэтлэн давах бололцоо олгооч. Эдүгээ хүртэл би чамайг юм бүхэн дээр үг дуугүй дагасан бүлгээ.

Харин чи одоо надад захирагд. Бурхан багшийн сургаалыг хамт дагая.

Сэтгэл минь ээ, уул толгод, гол ус, далай тэнгис бүгдээрээ хувиран өөрчлөгдөж, юм бүхэн гай гамшгаар дүүрэн билээ. Энэ ертөнцийн хаана нь баясал цэнгэл олж болох вэ? Бурхан багшийн сургаалыг дагаж, гэгээрлийн эрэгт түргэн хүрье".

5. Хэрэв хүн гэгээрэхийг чин сэтгэлээсээ хүсэж, иймэрхүү аргаар сэтгэлтэйгээ тэмцвээс санаа шулуудан гуйвж дайвалгүй урагшилна. Хүмүүс түүнийг дооглон инээлдэж, зангидсан нударгаар зодож занчиж, чулуугаар шидэж, илд далайн халдсан ч огт үл хэрэгсэж, үл уурлан хилэгнэнэ.

Түүний толгойг хөрөөдсөн ч сэтгэл нь үл хямарч үймэрнэ. Хэрэв сэтгэл нь харанхуйлвал Бурхан багшийн сургаалд үнэнч бусаа харуулна.

Түүнийг дооглон хөхрөлдөж, доромжлон дээрэлхэж, зодож нүдэж, мод хийгээд илдээр занчсан ч эгдүүцэл зэвүүцэл үл төрнө. Харин ч энэ бүхнийг амссанаар Бурхан багшийн сургаалд улам баттай сүсэглэнэ.

Гэгээрэхийн тулд хүршгүйд хүрч, давшгүйг давж, ноу байгаагаа бусдад өгөх хэрэгтэй.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Гэгээрэхийн тулд өдөрт ганцхан ширхэг будаагаар хооллож, асан дүрэлзэж буй гал руу явж ор гэсэн ч бэлэн байх хэрэгтэй.

Гэвч өгснөө өгсөн хэмээн бүү бод. Бардах буянаас, мартаж буян нь илүү гэдгийг санаж, энэ нь ухаалаг, зөв зүйтэй үйл мөн хэмээн түүнийг дага. Энэ нь үрдээ сүүлчийн хувцсаа тайлж өгсөн ч өгчихлөө хэмээн үл бодох, өвчтэй хүүхдээ асарсан ч асарч байна гэж үл санах эх лүгээ адил юм.

6. Эрт урьд цагт хаан амьдарч байв. Тэрбээр ухаантай, нигүүлсэнгүй сэтгэлтэй ард түмэндээ хайртай хүн байжээ. Хаант улс нь баян, ард иргэд нь амар амгалан, эв найртай амьдарч байлаа. Бурхан багшийн сургаалыг эзэн хаан хүндэтгэх учир улс даяар зарлиг буулгаж, ариун буянт сургаалыг зааж өгсөн хүнд үнэт эрдэнэс бэлэглэнэ гэв.

Үнэнийг ухаарахыг эрмэлзсэн хааны энэ хүсэл нь бурхдын ертөнцийнхнийг хүртэл баясгаж байв. Нэг удаа бурхан энэхүү тэмүүлэл нь үнэн эсэхийг сорихоор шийдэж, чөтгөрийн дүрээр ирж, хааны ордны хаалгыг тогшив.

"Би ариун сургаалыг мэднэ. Эзэн хаандаа энэ тухай уламжилна уу" гэж харуулд нь хэлжээ.

Үүнийг сонсоод баярласан хаан ихээхэн хүндэтгэн ордондоо урьж оруулаад ариун сургаалаас номлохыг хүсчээ. Тэгтэл чөтгөр хурц илд лүгээ адил аймшигтай соёогоо ярзайлгаж: "Би маш их өлсөж байна Ходоод хоосон, ном зааж чадахгүй" гэв.

Хаан идээ будаа зооглохыг урьсанд: "Би амьд хүний цус ууж, мах иднэ" гэв. Хааны хүү, охин хоёр нь өлссөн чөтгөрт өөрийгөө хоол болгоё гэлцэв. Чөтгөр хоёуланг идээд цадсангүй, хааныг идэхийг хүсчээ.

Хаан намуухан хариулсан нь: "Миний амь бол юу ч биш ээ. Гэвч чи намайг идчихвэл би яаж сургаалыг чинь сонсох билээ?" гэв.

Чөтгөр номлож эхэлсэн нь: Ховдог хомхой сэтгэлээс түгшүүр бухимдал үүсдэг, ховдог хомхой сэтгэлээс айдас төрдөг. Ховдог хомхой сэтгэлээс салж ангижирсан хүн түгшүүр бухимдлыг үл мэднэ. Тийм хүн юунаас ч үл айна". Энэ бүхнийг айлдчихаад нөгөөх чөтгөр бурхан болон хувирмагц хааны хүү, охин хоёр нь амилав.

7. Эрт урьд цагт үнэнийг эрсэн, хатуу зоригт, даяан хийдэг даяанч Хималайн ууланд сууж, төөрөгдлөөс ангижруулах сургаалыг эрж хайж байв. Түүнд өөр

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

юу ч хэрэггүй, энэ ертөнцийн эрдэнэсийг ч, бурхдын ертөнцөд мэндлэхийг ч үл хүсч байв.

Даяанчийн энэхүү эрмэлзэл тэмүүлэлд бурхан уярч, түүнийг сорихоор шийдэж, чөтгөрийн дүрээр Хималайн ууланд заларчээ.

"Энэ ертөнцөд юм бүхэн өөрчлөгдөн хувирч, буй болж, алга болдог" хэмээн дуулав.

Даяанч энэ дууг сонсож магнай нь тэнийв. Ангаж цангасан хүн горхины ус хоржигнон шоржигнохыг сонсох шиг, олзлогдсон хүн эрх чөлөөгөө олох шиг аятай таатай санагджээ.

"Энэ жинхэнэ үнэн, жинхэнэ сургаал мөн байна". Би үүнийг л эрж хайсан хэмээн бодож, дуулж буй хүнийг л олж харжээ. Тэрбээр гайхан тээнэгэлзэж, түүнд дөхөөд:

"Саяын дууг чи дуулсан уу? Хэрэв үнэхээр дуулсан бол цааш нь үргэлжлүүлнэ үү" гэв.

Чөтгөр: "Тийм ээ, би дуу дуулсан. Гэхдээ одоо өлсөж байгаа тул үргэлжлүүлж чадахгүй" гэв.

Даяанч дахин: "Би чамаас гуйж байна, дуугаа үргэлжлүүлэн дуулж өгөөч. Миний хайж буй гэгээн

үнэн энэ дуунд оршиж байна. Дуу дуусаагүйг ч ойлгож байна. Чи гүйцэд дуулахгүй юу" гэв.

Чөтгөр үгүй хэмээн толгой сэгсэрч:

"Би турж үхлээ. Хэрэв амьд хүний мах идэж, цус уувал энэ дуугаа үргэлжлүүлнэ" гэв.

Даяанч хэрэв дуугаа цааш нь үргэлжлүүлбэл сонссоныхоо эцэст өөрөө чөтгөрийн хоол болно хэмээн амлажээ.

Чөтгөр дуугаа дуустал нь дуулжээ. Дууг нь сийрүүлбэл:

"Хорвоо ертөнцөд бүх юм хувиран өөрчлөгдөж, буй болж, алга болдог. Төрж мэндлэх, үхэж үрэгдэхэд дадаж дассанаасаа салж чадвал мөнхийн амгаланг олж болно".

Даяанч дууны үгийг мод, чулуун дээр сийлж, дараа нь модон дээр гарч чөтгөрийн сарвайсан гар руу хоол нь болохоор үсрэв. Яг энэ мөчид чөтгөр бурхан болон хувирч даяанчийг газар унагалгүй барьж авав.

8. Эрт урьд цагт гэгээрэхийг хүссэн Садапрудита хэмээх хүн амьдарч байжээ. Сэтгэл

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

юугаан гагцхүү гэгээрэхэд л зориулж алдар нэр, ашиг хонжоог үл эрнэ. Нэг удаа тэнгэрээс дуудаж хэлсэн нь:

"Садапрарудита, зүүн зүг рүү яв. Хаашаа ч эргэж хазайлгүй шулуун явна шүү. Халуун хүйтнийг мартаж, алдар чинь мандах, нэр чинь хугарахыг үл хэрэгсэж, буян нүглийн алиныг нь ч орхиж, зүүн зүг рүү яв. Тэгвэл чи жинхэнэ багшаа олж гэгээрнэ".

Садапрарудита баясан хөөрч тэнгэрээс айлдсан ёсоор гэгээрэхийг хүсч зүүн зүгт оджээ. Тэрбээр тэнгэрээр хөнжил, уул толгодоор дэр хийж явж байлаа. Харийн нутагт хавчин хяхах, дайран доромжлохыг ч түүхгүй байлаа. Заримдаа хоол хүнсээ залгуулахын тулд хөлсөөр ажиллаж, эцэж цуцахыг үл мэдэн зүтгэнэ. Эцэст нь тэрбээр жинхэнэ багшаа олж золгож, түүндээ шавь орохыг хүсчээ.

Хүн буян үйлдэхийг хүсвэл, элдвийн саад бэрхшээл тохиолдоно гэж ярьдаг. Гэгээрэхийг хүсч зорьсон Садапрарудитагийн замд бэрхшээл олон тохиолдсон билээ.

Тэрбээр багшдаа халуун ногоо, цэцэг бэлэглэхийн тулд хөлсөөр ажиллахаар шийдтэл хэн ч хүлээж авсангүй. Очсон газарт нь түүнийг шулмын зардас нар салахгүй дагаж байв. Гэгээрэх зам нь

үнэхээр хүнд хэцүү, саад бартаатай байлаа.

Түүнд багшийнхаа ариун сургаалыг тэмдэглэх үзэг, цаас үгүй байсан тул хутга авч гараа зүсээд, багшийнхаа зааж сургасныг цусаараа тэмдэглэн бичжээ. Ингэж тэрбээр ариун үнэнийг ухаарчээ.

9. Эрт урьд цагт Судхана нэртэй жаал хүү амьдарч байжээ. Тэрбээр мөн адил үнэнийг эрж, гэгээрэхийг ХҮСЧ байлаа. Тэрбээр загасчидтай уулзан учирч тэнгис далайн хуулийг мэджээ. Тэрбээр эмчтэй уулзан учирч хүмүүсийг өрөвдөн хайрлаж, нигүүлсэнгүй хандахын ухааныг сурч, баян хүнтэй учирч аливаа юм өөрийн үнэ цэнэтэй байдгийг ойлгожээ.

Бясалгал хийж буй ламтай учирч, амгалан тайван сэтгэл нь нүүр царайнд нь хүртэл ул мөрөө үлдээж, бусдын сэтгэлийг ариусгаж, хүмүүст гайхалтай сайхан нөлөөлдөгийг мэджээ. Уужим сэтгэлтэй эмэгтэйтэй учирч, бусдын тусын тулд цаг үргэлж бэлэн байдгийг нь гайхан бишрэв. Гэгээрэхийн төлөө өөрийгөө хайрлахыг мартан, зүйл бүрээр сорин зовоож буй даяанчтай учраад, номын ёсоор гэгээрэхийн тулд өндөр хурц ирмэгтэй хад асганд авирч, гал дундуур туулах хэрэгтэй юм гэдгийг ухаарав. Хэрэв хүсвэл нүдээр харж, чихээр сонсч буй бүхэн үнэн зөв сургаал болно гэдгийг жаал хүү

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

ойлгожээ.

Тэрбээр хүч чадал сул дорой эмэгтэй хүн хүртэл гэгээрч болох сэтгэлтэй, гудамжинд тоглож буй хүүхэд ч бүхэл бүтэн өөрсдийн ертөнцтэй гэдгийг ухаарчээ. Байгалийн хуулиудад дуулгавартайяа захирагддаг сэтгэл нь оюун ухаантай гэдгийг дуу шуу цөөнтэй, бодь сэтгэлтэй хүнээс олж мэджээ.

Хүж уугиулахад ч Бурхан багшийн сургаал оршино. Цэцгээр чимэх урлагт хүртэл гэгээрэх зам мөр оршино. Нэг удаа ойд амарч байхдаа өмхөрсөн модны голоос шинэхэн мод ургаж буйг хараад газар дээр оршихын мөнх бусын үнэнийг ухаарчээ.

Үнэнийг эрэн тэмүүлсэн Судхана хүүгийн сэтгэлийг өдөр мандах нарны гэрэл, шөнө анивчих оддын туяа ариусгаж байлаа.

Жаал хүү хаана ч гэсэн гэгээрэх замыг хайж, зөв зүйтэй ном заалгаж, үнэнийг таних олон арга хэлбэрийг олж мэджээ.

Үнэхээр гэгээрэхийн тулд сэтгэлийн цайзны бөх батыг хамгаалж, түүнийг чимж байх хэрэгтэй аж. Сэтгэлийнхээ цайзны үүд хаалгыг нээн дэлгэж, сүсэг бишрэлийг үзүүлэн, ариун шүтээнээ хэмээн Бурхан

багшаа тахиж, итгэл бишрэлийн цэцгийг дэлгэрүүлж, баяр баясгалангийн хүжийг уугиулан асаах хэрэгтэй. асаах хэрэгтэй.

II

ГЭГЭЭРЭХ ЯНЗ ЯНЗЫН ЗАМ МӨР

1. Гэгээрэхийг тэмүүлсэн хүн сургаал зарлиг, сэтгэл төвлөрүүлэх ёс, оюун ухаан хэмээсэн гурван эрдмийг өөрийн болгох хэрэгтэй.

Сургаал зарлиг гэж юу вэ? Гэгээрэхийн зам мөрийг хөөсөн хүн төдийгүй ер нь хэн бүхэн эдгээр сургаал зарлигийг нарийн чанд сахиж мөрдөн бие, сэтгэл юүгээн анхааралтайяа ажиглаж, таван мэдрэхүйн үүд хаалгыг сонор соргог хамгаалж, хамгийн бага нүглийг хүртэл тэвчиж, буяныг бүтээж сэтгэлээ төгс төгөлдөр болгох шаардлагатай.

Санаа сэтгэлээ төвлөрүүлэх гэж юуг хэлнэ вэ? Энэ нь шунал хүслээсээ салж, муу үйлээс холдож, аажим аажмаар сэтгэлийн амгалан тайван байдлыг олохыг хэлнэ.

Оюун ухаан гэж юуг хэлнэ вэ? Энэ нь дөрвөн үнэнийг мэднэ гэсэн үг буюу тэдгээрийг өгүүлбээс, зовлонгийн үнэн, зовлонгийн шалтгааны үнэн, зовлонгоос салж болохын үнэн, зовлонг таслан зогсоох зам мөрийн үнэн эдгээр болой.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Энэ гурван эрдмийг үзэж судалдаг хүнийг Бурхан багшийн шавь гэдэг.

Дүр төрх, дуу хоолойгоороо огт төсгүй , эвэр ч үгүй илжиг нь үхрийн араас дагаж, би үхэр мөн хэмээн хичнээн ориловч түүнийг үхэр гэж хэн ч бодохгүй. Үүнтэй адил дээрх гурван эрдмийг үзэж судлаагүй мөртлөө өөрийгөө гэгээрэхийг хүсч тэмүүлэгч, Бурханы шавь хэмээн ярьж буй хүн үлэмж тэнэг билээ.

Тариачин, намар арвин ургац авахын тулд, юуны өмнө хавар цагаар газраа хагалж, үр цацаж, талбайгаа усалж, хортой ургамлыг түүж устгана. Үүнтэй адил гэгээрэхийг хүссэн хүн заавал гурван эрдмийг сурч судлах ёстой. Тариачин, өнөөдөр суулгасан үр нь өдөртөө соёолж, маргааш тариан түрүү найгаж, нөгөөдөр ургацаа хурааж авахсан гэж хичнээн хүсэвч, тийм ёсон үгүй. Үүнтэй адил гэгээрэхийг хүссэн хүн өнөөдөр хорвоогийн шунал тачаалаас салж, маргааш дадал заншлаасаа ангижирч, нөгөөдөр гэгээрч үл чадна.

Газарт унасан үр нь тариачны нөр их хөдөлмөрийн ачаар, жилийн нэг улирлыг нөгөө нь сольсны дараа соёолж, тариан түрүү найгана. Үүнтэй адил гэгээрэхийг хүссэн хүн, бурханы сургаал зарлиг болон санаа сэтгэлээ төвлөрүүлэх эрдэм, оюун ухаан

зэрэг гурван эрдмийг судлан, аажим аажмаар хорвоогийн шунал тачаал, дадал заншлаас ангижирч, эцэст нь гэгээрдэг.

2. Энэ ертөнцийн нэр алдар, эд баялгийг хүсэн мөрөөдөж, ховдог хомхой сэтгэлдээ автсан хүн гэгээрэх зам мөрийг олох нэн бэрх. Учир нь энэ ертөнцийн зугаа цэнгэл болон гэгээрэх зам мөрийн цэнгэлийг эрж хайх нь хоёр өөр зүйл юм.

Бидний зааснаар юм бүхний учир шалтгаан нь сэтгэл билээ. Хэрэв сэтгэл энэ ертөнцийн зугаа цэнгэлд автвал төөрөгдөл, зовлон зүдүүр л буй болно. Харин гэгээрэхийг хүсвэл гэгээрэл болон цэнгэл жаргал буй болно.

Тиймээс гэгээрэхийг хүсэгч нь сэтгэлээ ариусгаад Бурхан багшийн сургаалыг хазайлгүй дагаж, номлол бүхнийг мөрдөх учиртай. Хэрэв номлолыг мөрдвөл сэтгэлээ төвлөрүүлж чадна. Сэтгэлээ төвлөрүүлж чадвал, оюун ухаан нь саруул болно. Саруул оюун ухаан түүнийг гэгээрүүлнэ.

Чухамхүү эдгээр гурван эрдэм гэгээрэх зам мөр мөн билээ. Хүмүүс эдгээр гурван ухааныг эс судлах тул, урт хугацааны турш төөрч будилсан юм. Тэд гэгээрэх зам мөрийг олж, бусадтай хэрэлдэхийг цээрлэж, нам гүм бодол эрэгцүүлэлд автан, сэтгэлээ

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

ариусган түргэн гэгээрэхийг хичээх хэрэгтэй.

3. Хэрэв эл гурван эрдмийг дэлгэрэнгүй тайлбарлаваас энэ нь найман зам мөр, дөрвөн үзэл санаа, биеэ зөв авч явах дөрвөн хэм хэмжээ, таван хүч, зургаан заншил эдгээр болно.

Найман зөв зам мөр нь зөв үзэл, зөв сэтгэхүй, зөв үгс, зөв үйлс, зөв амьдрах арга, зөв тэмүүлэл, зөв дурсан санахуй, зөв бясалгал эдгээр юм.

Зөв үзэл нь дөрвөн үнэнийг танин мэдэж, учир шалтгааны үнэнд итгэж, эд юмсыг зөв үзэхийг хэлнэ.

Зөв сэтгэхүй нь хүслийн эрхэнд үл автах, шуналын эрхэнд үл орох, үл уурлах, бусдад хор үл хүргэх зэрэг юм.

Зөв үгс нь худал үл хэлэх, үл чалчих, үл хараах, хоёр нүүр үл гаргах юм.

Зөв үйл нь амьтны аминд үл халдах, хулгай үл хийх, буруу үл хурьцах юм.

Зөв амьдрах арга нь хүн ичмээр арчаагүй амьдрах аргаас зайлсхийхийг хэлнэ.

Зөв тэмүүлэл нь хэзээ ч үл залхуурах, зөв зорилгод

хүрэхийн тулд хүч чармайлт гаргахыг хэлнэ.

Зөв дурсах нь аливаа үйлийг бодолтойгоор үйлдэхийн нэр юм.

Зөв бясалгал нь өмнөө зөв зүйтэй зорилго тавих болон оюун ухаанаа гэгээрүүлэхийн тулд дотроо бясалгал үйлдэхийг хэлнэ.

4. Дөрвөн үзэл бодлыг тодруулбал:

Хүний бие бузартсан тул, түүнд дасахыг цээрлэ.

Аливаа мэдрэхүй зовлонг буй болгоно.

Хүний сэтгэл цаг үргэлж хөдөлгөөнд оршиж, байнга өөрчлөгдөн хувирч буй.

Энэ ертөнцөд бүх юм учир шалтгаан, нөхцөл байдлаас үүдэх тул мөнхийн чанартай юм нэгээхэн бээр ч үгүй бүлгээ.

5. Биеэ зөв авч явах дөрвөн хэм хэмжээг сийрүүлбэл:

Одоохондоо үүсээгүй нүглийг сэрэмжлэн зайлуулах.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Нэгэнт үүсч буй болсон нүглийг таслан зогсоох.

Буян буй болоход тус нэмэр үзүүлэх.

Буян улам арвижуулах эдгээр болой.

Хүн бүр биеэ зөв зүйтэй авч явахын дөрвөн хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

6. Таван хүчийг тодруулбал:
Сүсэглэн итгэх.

Хичээн зүтгэх.

Үйл хэргээ бодож эргэцүүлэх.

Бясалгах.

Оюун ухаанаа гэгээрүүлэх эдгээр болно.

Эдгээр таван хүч хүнийг гэгээрүүлнэ.

7. Зургаан дадал заншил бол өглөгч зан, сургаал зарлигийг мөрдөн сахих, тэвчээр хатуужил үзүүлэх, уйгагүй зүтгэх чадвар, бясалгал, оюун ухаан эдгээр юм. Хэрэв эл зургаан дадал заншлыг эзэмшиж чадвал төөрөгдлийн энэ эргээс гэгээрлийн цаад эрэгт хүрч

болно.

Өглөгч зан нь хомхой сэтгэлээ номхотгох, сургаалыг дагаж мөрдөх нь зөв зүйтэй үйл бүтээх, тэвчээр хатуужил нь үл уцаарлах, уйгагүй зүтгэх нь залхуу хойрго занг устгах, бясалгал нь сэтгэлээ амар тайван болгох, оюун ухаан нь ухаангүй мунхаг сэтгэлийг гэгээрүүлэхийг хэлнэ.

Цайзны суурь лугаа үлгэрлэж болох өглөгч зан, сургаал зарлигийг дагаж баримтлах нь Бурхан багшийг дагах нэгэн ёсны үндэс суурь болно. Тэвчээр, уйгагүй зүтгэл хоёр нь цайзны хана лугаа адил гадаад гай гамшгаас хамгаална. Бясалгал болоод оюун ухаан нь амьдрал, үхэлд хэт дасахаас зайлсхийж, өөрийгөө хамгаалах зэвсэг юм. Тэд тулалдаанд орж буй цэрэг эрийг хамгаалах дуулга юм.

Гуйсанд өгөх нь өглөг боловч, жинхэнэ өглөг биш ээ. Үнэн өглөг нь хэн ч, юу ч гуйхгүй байхад нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлэн өгөхийг хэлнэ. Хааяа өгөх нь жинхэнэ өглөг биш ээ. Жинхэнэ өглөг нь үргэлж өгөхийг хэлнэ.

Хэрэв өглөгийнхөө дараа харамсах юм уу, өгсөндөө бардаж биеэ тоох зан гаргавал энэ нь жинхэнэ өглөг биш ээ. Сайн үйл бүтээсэндээ баярлан

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

хөөрч, өглөгийн эзэн өөрийгөө, юу өгснөө, хэнд өгснөө мартаж чадвал сая жинхэнэ өглөг.

Зөв өргөл барьцыг хожим нь шан харамж горьдож эс өргөнө. Тэр нь нигүүлсэнгүй ариун сэтгэлээс үүдсэн, өөрт болон өрөөлд гэгээрэхийн ерөөл билээ.

Энэхүү ертөнцөд ямар ч хөрөнгөгүй ядуу хүн хүртэл өргөж чадах долоон янзын өргөл барьц буй. Нэгдүгээрт, бие юугаан өргөл болгох. Энэ нь хүч хөдөлмөрөө зориулан зүтгэхийн нэр, түүний дээд хэлбэр нь өөрийн амь биеийг үл хайрлан зүтгэх явдал болой. Үүний тухай дараачийн хэсэгт өгүүлнэ. Хоёрдугаарт, сэтгэл юүгээн өргөл болгох. Энэ нь эргэн тойрон буй хүмүүс, эд юмст анхаарал халамжтай хандахыг хэлнэ. Гуравдугаарт, мэлмий юугаан өргөх. Энэ нь дэргэдэх хүмүүсээ амирлангуй болгох төлөв даруу, намуухан харц юм. Дөрөвдүгээрт, булбарай зөөлөн нүүр царайгаа өргөл болгох. Энэ нь үргэлж халуун дотно мишээхийн нэр билээ. Тавдугаарт, үг яриагаа өргөл болгох. Энэ бол анхаарал халамж, хайр ивээлийн үгс юм. Зургадугаарт, байр суудлаа өргөл болгох. Энэ бол байр сууриа бусдад тавьж өгөхийн нэр бүлгээ. Долдугаарт, орон байраа өргөл барьц болгох. Энэ нь гэр орондоо бусдыг хонуулахын нэр билээ. Эдгээрийг аливаа хүн өдөр тутмын амьдралдаа үйлдэж чадна.

8. Эрт урьд цагт Саттва хэмээх хунтайж байжээ. Нэгэнтээ хоёр ахтайгаа цуг ойд тоглож наадахаар очтол, долоон зулзага төрүүлсэн эм бартай таарчээ. Бар өлсгөлөн байсан учраас зулзагуудаа идэхийг завдаж байв.

Хоёр ах нь айн сандарч, зайлан зугтав. Гагцхүү Саттва хунтайж биеэ өргөл болгож, өлсгөлөн барыг хооллохоор шийджээ. Тэрбээр өндөр, эгц хад асга оёд мацан авирч, өөрийн биеэр эм барыг хооллов. Бар цадаж, зулзагаа оролдсонгүй.

Саттва хунтайжийн сэтгэл гагцхүү гэгээрэхийг л хүсчээ.

"Миний бие хэврэг, хувирамтгай. Одоо болтол би бээр хэнд ч өглөг өгсөнгүй, гагцхүү өөрийн биеийг бодож, тордож байжээ. Эдүгээ эм бард биеэрээ өргөл барьж гэгээрэе". Хунтайж ингэж шийдээд ёсоор болгож эм бард биеэрээ өргөл барьжээ.

9. Бурхан багшийн үнэнч шавь бол энэрэнгүй, нигүүлсэнгүй, баясгалантай, амарлингуй сэтгэлийн дөрвөн байдлыг ухааран мэдвээс зохилтой.

Энэрэхийг ухаарвал, хүсэл шуналаасаа сална. Нигүүлсэнгүйг ойлговол уур хилэнгээсээ ангижирна. Баяр баясгаланг танин мэдвэл зовлонг таслан

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

зогсооно. Амарлингуйг ухаарвал өөрт чинь туслах хийгээд гомдоохын алинд ч амгалан тайван хандана.

Хүмүүст жаргал цэнгэл эдлүүлэх нь их энэрэнгүй сэтгэл, тэднийг шаналал зовлонгоос ангижруулах нь их нигүүлсэнгүй сэтгэл юм. Хүмүүст баяр баясгалантай.

хандах нь их баяр жаргал юм. Бүх юманд, бүгдэд тэгш хандаж дээр доор хэмээн үл ялгах нь их амарлингуй сэтгэл юм.

Иймээс сэтгэлээ төгс засаж, шунал хүсэл, уур хилэн, зовлон зүдүүр, хайрлах, үзэн ядахаас салгах их энэрэнгүй, их нигүүлсэнгүй, их баясгалантай, их амарлингуй сэтгэлийг ухаарах хэрэгтэй бүлгээ. Гэхдээ дассан нохойгоо хөөж туухад хэцүү байдагтай адил муу санаа бодлыг хөөн туухад бэрх билээ. Айсан согоо хэдхэн дэгдээд алга болдогтой адил сайхан санаа амархан арилна. Тэгээд ч муу санаа бодлоосоо салах нь чулуун дээр сийлсэн үгийг арилгахаас хэцүү бүлгээ. Харин сайн санаа бол усан дээр бичсэн лүгээ адил агшнаа замхарна. Тиймээс гэгээрэхэд бэрх юм.

10. Ялж төгс нөгчсөн багшийн шавь Срона нь баян тансаг айлд төржээ. Тэрбээр төрөлхийн сул дорой, өвчин эмгэгтэй хүү байжээ. Амарлингуй оршигч багштай учирсан тэрбээр Түүнд шавь орж, номыг дагаж, өөрийгөө зүйл бүрээр сорьж, хөлөө цус гартал

шархтуулж байсан боловч нэг л гэгээрэхгүй байлаа.

Бүхнийг айлдагч багш Сронаг өрөвдөж хэлсэн нь:

"Срона, чи гэртээ байхдаа босоо ятга тоглож сурсан бизээ. Чавхдасыг хэтэрхий хүчтэй, эсвэл хэтэрхий сул татвал уянгалаг сайхан дуу гарахгүй гэдгийг чи мэднэ. Чавхдасыг хэтэрхий чанга бус, хэтэрхий сул бус, яг тааруулан татвал уянгалаг дуу гарна.

Гэгээрэх зам мөр үүнтэй адил билээ. Хэрэв залхуурвал үл гэгээрнэ, мөн хэтэрхий хичээж, хэтрүүлж хийвэл үл гэгээрнэ, хэмжээгээ мэдэж, тааруулах хэрэгтэй".

Срона энэхүү зөвлөгөөг сонсоод удалгүй гэгээрэв.

11. Эрт урьд цагт таван янзын зэвсэг гарамгай эзэмшсэн хунтайж байжээ. Тэрбээр сургууль номоо өндөрлөөд гэрийн зүг эргэв. Замдаа хээр талд үс ноос нь тэр аяараа өөх тос болсон аймшигт амьтантай таарчээ.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Тэр амьтан хунтайж руу дайрав. Хунтайж нум сумаар харватал сум нь аймшигт амьтны өөх тостой үсэнд наалдаж ямар ч гэм хор учруулсангүй. Илд, ойл, мод, жадны аль нь ч өөх тостой үс ноосонд нь наалдсан аж. Ямар ч зэвсэггүй үлдсэн хунтайж зангидсан нударгаараа цохиж, хөлөөрөө өшиглөтөл, гар хөл нь бас наалдаж, хунтайж өөрөө агаарт дүүжлэгджээ. Тэрбээр толгойгоороо мөнөөхөн гайхлын цээж рүү цохитол толгой нь бас наалдчихав.

Аймшигт амьтан хэлсэн нь: "Одоо чи миний гарт орлоо. Би чамайг иднэ" гэв.

Хунтайж инээд алдан: "Чи намайг ямар ч зэвсэггүй болсон гэж бодов уу? Үгүй шүү, би алтан зэвсэгтэйгээ үлдсэн. Хэрэв чи намайг залгивал миний зэвсэг чамайг дотроос чинь хүү татна" гэв.

Айж сандарсан гайхал амьтан "Яаж тэр вэ?" гэж асуухад, "Яахав, үнэний хүчээр" гэж хунтайж өгүүлжээ.

Чингээд аймшигт амьтан хунтайжийг чөлөөлж, түүгээр сургаал номлол заалган хойшид мууг үйлдэхээ больсон ажээ.

12. Үйлдсэн үйлээсээ болон бусдаас ичих зовохыг мэдэхээ боливол нийгмийн хэв журам зөрчигдөнө.

Хэрэв өөрөөсөө болон бусдаас ичиж зовбол хэв журам сахихад тустай. Чухамхүү ичиж зовох сэтгэлийн ачаар хүмүүс эцэг эх, багш нар, ахмадуудаа дээдлэн хүндэлж, ах, эгч, дүү нарын харьцаанд ёс журам сахина. Өөрийн үйлийг эргэн тунгааж, өөрөөсөө ичиж, бусдын үйлийг харж ичиж зовох нь чухал юм.

Хэрэв хүн наманчилж чадвал, нүгэл нь нүгэл бус болж арилна. Эс чадвал мөнхийн нүгэл болж, сэтгэл зүрхийг нь зовоож шаналгана.

Зөв сургаал сонсоод байн байн эргэцүүлэн бодож, сурч судалж, дагаж мөрдвөл түүнийг ухаарна. Бодож эргэцүүлэхгүй, дагаж мөрдөхгүй бол сонссон ч эс ухаарна.

Итгэл бишрэл, ичих нүүр, төлөв даруу зан, хичээл зүтгэл болон оюун ухаан нь энэ ертөнцийн агуу их хүч юм. Эдгээрээс хамгийн чухал нь оюун ухааны хүч бөгөөд бусад дөрөв нь түүний хүчийг нөхөн гүйцээдэг юм.

Гэгээрэхийг зорихдоо аар саар юм хөөцөлдөж, дэмий чалчин цаг алдаж, их унтаж болохгүй. Энэ бүхэн зөв зам мөрөөс хазайлгадаг.

13. Хүмүүс гэгээрэхийн төлөө адилхан зүтгэвч нэг

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

хэсэг нь эрт, нөгөө нь нэлээд хожуу гэгээрдэг. Тиймээс бусад хүмүүс түрүүлж гэгээрснийг хараад гуньж гутрах хэрэггүй.

Нум сум харваж сурч эхлэхэд сум нь байгаа онох нь ховор. Гэвч суралцахаа эс зогсвол сум байндаа тусах нь олширно. Гол мөрөн ямагт мушгиран урсах боловч эцсийн эцэст далайд цутгадаг. Гэгээрэх нь үүнтэй адил юм. Хэрэв тасралтгүй эрж хайвал зайлшгүй гэгээрнэ.

Бидний нэг бус удаа тэмдэглэснээр нүдэнд харагдах юм бүхэнд сургаал нуугдаж буй. Үүнтэй адил аливаа юманд гэгээрэх учир шалтгаан буй.

Хүж уугиулаад анхилуун сайхан нь агаарт түгэн тархаж буйг ажигладаг хүн байжээ. Тансаг анхилуун утаа нь байна, мөн байхгүй, энэ анхилуун нь явдаг ч үгүй, ирдэг ч үгүй гэж хэлж болно. Үүнийг таньж мэдмэгцээ тэр хүн гэгээрчээ.

Нэг хүн замаар явж байгаад хөлөндөө өргөс оруулжээ. Өргөс нь хатгаж өвтгөхөд байнгын нэгэн сэтгэл үгүй, зүйл бүрийн хүчний нөлөөн дор сэтгэл өөрчлөгдөн хувирдгийг ухаарчээ. Үлгэрлэвэл, түгшиж бачимдсан сэтгэл нь шунал тачаал болон хувирч, амарлингуй тайван сэтгэл нь гоо сайхан болжээ. Үүнийг ухаармагцаа хүн гэгээрчээ.

Нэгэн харамч хүн байжээ. Тэрбээр ховдог хомхой сэтгэлийн тухай эргэцүүлэн бодоод ийм сэтгэлийн түлээ түлш нь эцсийн эцэст оюун ухааны гал түймэр болж дүрэлзэж болох юм хэмээн дүгнэжээ. Үүнийг ухаармагцаа тэрбээр гэгээрчээ.

"Сэтгэлээ тэгшил. Хэрэв сэтгэл тэгширвэл энэ ертөнцийн газар шороо мөн адил тэгширнэ". Энэхүү сургаалыг сонссон нэг хүн ертөнцийн бүх ялгаа нь тэдгээрийг сэтгэл хэрхэн үздэгээс шалтгаална гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүнийг ухаармагцаа тэрбээр гэгээрчээ. Иймэрхүү маягаар гэгээрэх учир шалтгаан эцэс төгсгөлгүй бүлгээ.

III СҮСЭГ БИШРЭЛИЙН ЗАМ

1. Бурхан багш, түүний ном болон лам хувраг хэмээх гурван эрдэнэд шүтсэн хүнийг Бурхан багшийн шавь гэж нэрлэнэ. Харин Бурхан багшийн шавь нь сахил хийгээд бишрэл, өгөөмөр сэтгэл, оюун ухааныг эрхэмлэн дагана.

Шавь нь амьтны амь үл таслах, үл хулгайлах, буруу үл хурьцах, худал үл хэлэх, дарс үл уух ээрэг таван сахилыг мөрдлөг болгоно.

Бурхан багшийн оюун ухаанд сүсэглэн итгэх нь

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

шавийн итгэл бишрэл юм. Ховдог хомхой, харамч сэтгэлээсээ салж, өргөл барьц өргөх нь шавийн өглөгч сэтгэл билээ. Учир шалтгааны шүтэн барилдах үнэнийг ухаараад хорвоо дээр бүх юм урсаж, хувиран өөрчлөгдөж буйг ухаарах нь шавийн оюун ухаан бүлгээ.

Зүүн зүг рүү налж ургасан мод унахдаа зайлшгүй зүүн зүгтээ унадагтай адил Бурхан багшид гүнээ итгэж сургаалыг нь дагасан хүн Бурхан багшийн ертөнцөд заавал мэндэлнэ.

2. Бурхан багшийн шавь бол Бурхан багш, Түүний сургаал болон лам хуврагт итгэн биширдэг хүн юм.

Бурхан багш бол өөрөө гэгээрч, хүмүүсийг аварч буй хүн юм. Бурхан багшийн заасныг Сургаал хэмээн нэрлэнэ. Лам хуврагууд нь сургаалыг дагаж, зөв замаар явж буй хүмүүсийн ах дүүгийн холбоо бүхий нийгэмлэг болно.

Хэдийгээр Бурхан багш, сургаал, лам хувраг гурав тус тусдаа оршдог боловч нэгэн нэгдмэл цул чанарыг бүрдүүлдэг. Бурхан багш сургаалдаа биелж, сургаал нь лам хуврагуудад биеллээ олдог тул энэ гурав нэгдмэл болой.

Сургаал болон лам хуврагт итгэж сүсэглэх нь

Бурхан багшид итгэж сүсэглэнэ гэсэн үг. Бурхан багшид итгэх нь сургаал болон лам хуврагт итгэнэ гэсэн хэрэг.

Тиймээс хүмүүс ганц Бурхан багшид итгэж сүсэглэснээр аврагдаж болно. Бурхан багш хүн бүрийг Өөрийн хүүхэд лүгээ адил хайрлах тул хүүхдүүд ээждээ итгэхтэй адил Бурхан багшид хүмүүс итгэж чадвал Бурхан багшийг ямар ч гэсэн амилуулан үзэж, цугаараа аврагдана.

Бурхан багшид итгэдэг хүн ямагт Түүний гэгээн гэрлээр гийж, Түүний анхилуун үнэрт ариусна.

3. Энэ ертөнцөд Бурхан багшид итгэхээс илүү ариун сайхан юм байхгүй. Хэрэв хүн амьдралдаа ганц удаа ч болов Бурхан багшийн нэр алдрыг сонсч, Түүнд итгэж баясвал хамгийн их зол жаргалтай учирсан гэж хэлэх хэрэгтэй.

Тиймээс Бурхан багшид итгэсний баяр баясгаланг амсахын тулд энэ ертөнцийг бүхлээр нь залгисан галд ч орох хэрэгтэй юм.

Үнэнийг хэлэхэд Бурхан багштай учрах нэн бэрх, сургаалыг нь түгээн сурталчилж байгаа хүнийг олох бэрх, энэ сургаалд итгэх нь бүр бэрх билээ.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Та одоо уулзахад амаргүй номлогчтой учирч, тэр болгон аз тохиож сонсоход бэрх сургаал сонслоо. Амьдралын ийм ховорхон тохиолдлыг алдалгүй Бурхан багшид итгэж сүсэглэх хэрэгтэй.

4. Итгэл бишрэл бол хүний хамгийн сайн хань, энэ ертөнцийн аян замынх нь хүнс, хамгийн үнэтэй эрдэнэ нь юм.

Итгэл бишрэл бол Бурханы шашныг, мөн буян бүхнийг хүлээн авч буй цагаан мутар юм. Итгэл бишрэл бол бузрыг шатаагч, хүний сэтгэлийг ариусгагч, зөв зам мөрт залагч, Бурхан багшийн зам мөрийг дагах хүслийг бадраагч гал бүлгээ.

Итгэл бишрэл сэтгэлийг баян болгож, ховдог шунахай болон бардам занг үндсээр нь устгаж, төлөв даруу байхыг хүнд зааж сургана. Түүний ачаар хүний оюун ухаан гялалзаж, үйлс нь гэгээн болмуй. Итгэл бишрэл нь саад бэрхшээлээс үл шантарч, гадаад нөхцөл байдлын боол үл болох, элдвийн юманд уруу эс татагдах хүч өгдөг юм.

Итгэл бишрэл нь урт удаан, уйтгартай замд хүний сэтгэлийг засч, гэгээрэхэд хөтлөдөг.

Итгэл бишрэлийн ачаар хүн өөрийгөө үргэлж Бурхан багшийн дэргэд Бурхан багшийн ивээлд буй

хэмээн санадаг. Итгэл бишрэл хүний бүдүүн хадуун, амиа хичээсэн сэтгэлийг зөөлрүүлж, хүнийг найрсаг, нүдэнд дулаахан болгодог.

5. Сэтгэлдээ сүсэг итгэлийг агуулсан хүн сонорт нь хүрсэн аливаа дуу хоолойноос Бурхан багшийн сургаалыг ялгаж, түүнд баярлан баясах оюун ухаантай болно. Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм үүсч буй болохыг ойлгож, үүнийг ингэх л ёстой хэмээн хүлээн авах чадвартай оюун ухааныг түүнд хайрладаг.

Тэрбээр энэ ертөнцийн хувирч буй бүх зүйлд нэгэн өөрчлөгдөшгүй үнэн буйг ойлгож, амьдрал өөдлөж доройтоход үл гайхаж, үл харамсах чадвар бүхий оюун ухаантай болмуй.

Итгэл бишрэл нь нүглээ наманчлах, уяран хайлах, мөргөж залбирах гурван хэлбэрээр илэрдэг.

Сэтгэлдээ итгэл бишрэлтэй хүн бол үйл ажлаа гүн гүнзгий задлан шинжилж, нүгэл, бузар булайг үйлдсэндээ харамсан гуньдаг. Өөр хүн сайныг бүтээхийг хараад өөрөө үйлдсэнтэй адил баярлаж, түүнд сайн сайхан бүхнийг хүсч ерөөдөг. Тэрбээр үргэлж Бурхан багштай хамт байж, Бурхан багштай хамт үйлс бүтээж, Бурхан багштай хамт амьдрахыг хүсдэг.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Сүсэгтэй сэтгэл нь бурхан багш түүнийг Өөрийн ертөнцөд залан аваачиж буйд баярлан баяссан чин сэтгэл, гүн гүнзгий сэтгэл юм.

Хаа сайгүй Бурхан багшийг өргөмжлөн дээдлэх магтаалд итгэн сүсэглэж, баясагч хүнд Бурхан багш зүрх сэтгэлийнхээ хүчийг хайрлан, Өөрийн ертөнцөд аваачиж, дахин төөрөлдөхөөс хамгаална.

6. Бурхан багшид итгэн сүсэглэх нь хүн бүрийн сэтгэлийн гүнд буй Бурхан багшийн мөн чанарын илрэл юм. Учир нь Бурхан багшийг танин мэдсэн хүн бол өөрөө Бурхан багш юм. Бурхан багшид итгэсэн хүн бол өөрөө Бурхан багш бүлгээ.

Хэдийгээр Бурхан багшийн мөн чанар хүн бүрт буй боловч, тэр нь хорвоогийн шунал тачаалын хир буртагт гүн гүнзгий нуугдмал учраас бүрэн илэрч хөгждөггүй. Ховдог хомхой сэтгэл, уур уцаарын эргүүлэгт Бурхан багш руу тэмүүлсэн цэвэр ариун сэтгэл буй болно гэж үү?

Хорт мод ургадаг төгөлд анхилуун сайхан үнэрт мод ургадаггүй. Хэрэв хорт модны дунд анхилуун үнэрт мод ургавал гайхамшигт явдал болно. Түүнчлэн хүмүүсийн сэтгэлд Бурхан руу тэмүүлсэн, Бурханд итгэж сүсэглэсэн сэтгэл сэрвэл энэ нь гайхамшиг мөн билээ.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Тиймээс Бурхан багшид итгэж сүсэглэсэн хүмүүсийн сэтгэлийг үндэсгүй итгэл хэмээнэ. Ингэхийн учир гэвэл итгэлийн үндэс нь хүмүүсийн сэтгэлд бус, Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлд оршдогт билээ.

7. Эл учир итгэл бишрэл нь ариун чанартай юм. Тэр нь зөв зам руу залан чиглүүлж, буянт үйлийн эх булаг болмуй. Гэвч энэхүү итгэл бишрэл нь зөв замыг эрж хайж буй хүмүүсийн сэтгэлд ч тийм амархан буй болохгүй. Учир юун гэвэл таван эргэлзэл саад болмой.

Нэгдүгээрт, Бурхан багшийн оюун ухаанд эргэлзэх.

Хоёрдугаарт, сургаал үнэн гэдэгт эргэлзэх.

Гуравдугаарт, Бурхан багшийн сургаалыг номлогч хүнд эргэлзэх.

Дөрөвдүгээрт, зөв зам мөрийг эрж хайхдаа төөрч будилах.

Тавдугаарт, биеэ дэндүү тоож, Бурхан багшийн сургаалд итгэж сүсэглэн дагасан хүмүүст үл итгэсэннээс тэвчээр алдах эдгээр болно.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Эргэлзэхээс илүү аймшигтай юм хорвоо дээр үгүй. Эргэлзэл хүмүүсийг бие биенээс нь хөндийрүүлж, найз нөхрийн холбоог тасалдаг хор билээ. Энэ бол хамтран зүтгэгчдийн амь насанд аюултай чинжаал хутга, найз нөхдийн сэтгэл рүү шигдэн орох өргөс билээ.

Тиймээс итгэл бишрэлийг олсон хүмүүс аль дивангарт энэрэнгүй сэтгэлт Бурхан багш, итгэлийг сэтгэлд нь суулгасныг мэдэх ёстой.

Бурхан багшийн мутар хүний сэтгэлд итгэлийн гэрлийг асааж, эргэлзлийн харанхуйг арилгасан бүлгээ.

Аль дивангарт хүмүүсийн сэтгэлд итгэл бишрэлийг суулгасан Бурхан багшид баярлаж, Бурхан багшийн хэмжээлшгүй энэрэнгүй сэтгэлд баясан хөөрч, итгэл сүсгийг олсон хүн энэ хорвоод амьдарч байхдаа ч Бурхан багшийн ертөнцөд мэндэлж чадмой.

Энэхүү ертөнцөд хүн болж төрөх үнэхээр хэцүү. Бурхан багшийн сургаалыг олж сонсох ч хэцүү. ИТГЭЛ бишрэлийг олох бүр хэцүү. Тиймээс хэн хүн энэхүү сургаалыг олж сонсохын төлөө бололцоотой бүхнийг хийх хэрэгтэй.

IV

АРИУН ШУДАРГА ҮГ

1. Өөрийг нь хараалаа, доромжиллоо, зодож занчлаа хэмээн бодож буй хүний гомдол тайлагддаггүй.

Гомдсон тухайгаа цаг үргэлж бодвол гомдол үл тайлагдана. Гомдлоо мартсанаар тайлж болно.

Муу дээвэрлэсэн байшинд дусаал гоождогтой адил өөрийгөө үл хянах хүний сэтгэлд хүсэл шунал дүүрнэ.

Залхуу хойрго зан бол үхэлд хүргэх хамгийн дөт зам, хөдөлмөрч зан бол амьдралын зам мөн билээ. Мунхаг хүн залхуурч, ухаантай хүн хөдөлмөрлөнө.

Нум сум хийж буй уран хүн сумаа харуулдан засч, тэгш болгохтой адил ухаант хүн сэтгэлээ засч тэгш шулуун болгоно.

Хөдөлж хөөрөх нь амархан, тайвширч номхрох нь амаргүй, сэтгэлээ барих хэцүү. Түүнийг тайвшруулснаар хүн амарлингуй болно.

Хүнд өс хонзонт этгээд, эсвэл дайснаас нь илүү хор хөнөөлийг сэтгэл нь хүргэдэг.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Хүсэл, шунал, уур хилэн, муу юмнаас сэтгэлээ хол байлгаж чадсан хүн л жинхэнэ амарлингуйг хүртэнэ.

2. Ажил үйлсээрээ батлахгүй сайхан үг урсгах нь үнэр танаргүй гоё цэцэг лүгээ адил бүлгээ.

Цэцэгсийн үнэр салхины эсрэг үл анхилна. Сайн хүний тухай цуу салхины эсрэг ч даян дэлхийгээр тарж түгнэ.

Нойр үл хүрэх хүнд шөнө урт, ядарч цуцсан аянчинд зам урт, зөв сургаал үл мэдэх хүнд төөрөгдөл удаан санагдана.

Аян замд гарахдаа өөртэйгээ эн тэнцүү, эсвэл илүү хүнтэй цуг яваарай. Мунхаг хүн дагуулснаас ганцаар явах нь дээр.

Зэрлэг араатнаас бүү ай, муу нөхрөөс ай. Зэрлэг араатан зөвхөн биеийг гэмтээнэ, муу нөхөр сэтгэлийг гэмтээж шархлуулна.

Үр хүүхэд, эд баялгийнхаа төлөө сэтгэл зовсоор хүн шаналж гүйцдэг. Хүн өөрөө өөртөө ч үл харьяалагдах атлаа, үр хүүхэд, эд баялгаа яагаад өөрийн хэмээн тооцно вэ?

Тэнэгээ мэддэг тэнэг хүн өөрийгөө ухаантай гэж бодох тэнэгээс дээр бүлгээ.

Хоолны амтыг халбага мэддэггүйтэй адил, тэнэг хүн ухаантай хүнтэй ярилцаж суухдаа сургаалыг нь ойлгодоггүй.

Шинэ сүү үл гашлахтай адил муу үйлийн хариу тэр дороо үл ирнэ. Гэвч тэр нь үндсэн доор унтралгүй уугих гал адил эцэстээ дүрэлзэн асч түймэр гарна.

Ухаан муутай хүн нэр алдар, ашиг хонжооны хойноос хөөцөлдөж цаг үргэлж зовж зүдэрнэ. Тэрбээр үргэлж албан тушаал ахих, илүү эрх дархтай болох, илүү ашиг хонжоо олохыг хүсэх тул байнга зовж шаналдаг.

Алдааг хэлж, нүглийг зааж, дутагдлыг илчилсэн хүнийг нуучихсан эрдэнийг олж өгсөн хүнтэй адил үзэж, хүндэтгэх хэрэгтэй.

3. Бурхан багшийн сургаалд баярлагч хүн цэвэр ариун сэтгэлтэй, тэр нь сургаалаар ариусч байдаг тул шөнө нойр бөхтэй байдаг.

Мужаан мод харуулдах, гарын дүйтэй хүн сумаа тэгшлэх, газар малтагч суваг ухаж ус урсгахтай адил ухаант хүн сэтгэлээ засч янзалж байдаг.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Салхи үлээхэд хад асга үл доргих лугаа адил, ухаант хүнийг яаж ч загнаж зандагчсан, яаж ч магтаж өргөмжилсөн сэтгэл нь үл донсолж, амгалан байдлаа үл алдана.

Өөрийгөө ялах нь дайны талбарт тоо томшгүй олон цэргийг дарж ялалт байгуулснаас илүү юм.

Зөв сургаалыг мэдэлгүй зуун жил амьдарснаас, мэдээд ганцхан хоног амьдарсан нь дээр.

Аливаа хүн үнэхээр өөртөө хайртай юм бол өөрийгөө нүглээс ангид байлгах ёстой. Залуу зандан нас, эр бие гүйцэх цаг, өтөлж хөгшрөх үеийнхээ аль нэгэнд хүн, амьдралдаа нэг удаа ч болов сэргж сэхээрэх ёстой.

Энэ ертөнц мөнхийн гал дунд орших бүлгээ. Энэ ертөнцөд хүсэл шунал, уур хилэн, мунхагийн гал дүрэлзэн амой. Эл шатаж буй байшингаас шалавхан зайлах хэрэгтэй.

Энэхүү ертөнц, үнэхээр хөөс, аалзны шүлс, хир буртаг дүүрэн сав лугаа адил бүлгээ. Тиймээс хүн бүр ариун сэтгэлээ ариг гамтай хадгалах хэрэгтэй.

4. Бурхан багшийн сургаал.нүгэл үл үйлдэж, сайн үйлс бүтээн сэтгэлээ ариусгахыг заадаг юм.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

Хатуужил тэвчээртэй байхыг сурах хэцүү ч, эцсийн эцэст алдрын титмийг тэвчээртэй хүн л хүртдэг.

Хүн цэвэр ариун амьдрах ёстой. Гомдооход гомдох хэрэггүй. Уйтгар гунигийн цаг ирэхэд уйдаж гуних хэрэггүй. Ховдог хомхой сэтгэлтний дунд байхдаа ховдог хомхой сэтгэлтэй бүү бол. Аливаа юмны тухай бол миний юм гэж бүү бод.

Эрүүл мэнд бол хамгийн сайн давуу тал. Сэтгэл хангалуун байх нь хамгийн их баялаг, итгэл найдвар бол хамгийн ойр дотнын байдал, гэгээрэх нь хамгийн аятай таатай байдал юм.

Нүглээс холдсондоо баярлаж, анир чимээгүйд баясч, Бурхан багшийн сургаалд хөөрч буй хүн юунаас ч үл айна.

Сайн, мууг ялгахдаа сайнд нь дасаж дадаж үл болно. Сайн, мууг хооронд нь ялгаснаар уйтгар гуниг, айх эмээх сэтгэл буй болж, бачимдах давчдах эхэлнэ.

5. Зэв төмрөөс үүсэж эргээд төмрөө иддэгтэй адил, нүгэл нь хүнээс буй болж, эргээд хүнээ иддэг.

Уншлага залбирал байсаар байтал тэдгээрийг

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

уншихгүй нь уншлага залбиралын бузар юм. Байшин барилга буй атал, түүнийгээ засч янзлахгүй нь байшингийн бузар юм. Бие махбод байсаар байтал түүнийгээ хэрэгсэхгүй нь биеийн бузар болой.

Буян эс үйлдэх нь хүний бузар мөн. Мөнгө харамлах нь өглөгийн бузар. Нүгэл бол энэ хийгээд хойт ертөнцийн бузар юм.

Гэвч хамгийн адгийнх нь мунхагийн бузар бүлгээ. Үүнийг эс арилгаваас хүн ариусч үл чадна.

Өөрийнхөө шившгээс ичдэггүй хүн болох амархан, хэрээ лүгээ адил эрээ цээргүй болох ч амархан, цэвдэг сэтгэлтэй, бусдыг гомдоодог, түүнийгээ анзаарахгүй байх амархан.

Төлөв даруу зантай, бусдыг хүндэтгэх, дасаж дадсанаасаа салж ангижрах сэтгэлтэй хийгээд буян үйлдэж, ухаантай болох хэцүү.

Бусдын алдаа мадаг нүдэнд шууд тусдаг, харин өөрийнхийг олж харах хэцүү. Бусдын нүглийн тухай цууг дэвэн дэлхийгээр дорхноо тараачихдаг мөртлөө, бид өөрсдийнхөө нүглийг гартаа буй даалууг нуух мэт хав дардаг.

Тэнгэрт шувууд, утаа манан, салхи шуурганы

мөр үгүйтэй адил, буруу номонд гэгээрэх нь ер үгүй. Юунд ч байнгын тогтсон чанар үгүй бүлгээ. Харин гэгээрсэн хүнд хямрах бачимдах сэтгэл үгүй.

6. Цайзыг дотроос нь ч, гаднаас нь ч найдвартай хамгаалах адил биеийг тэгэж хамгаалах хэрэгтэй. Үүний тулд сонор сэрэмжээ нэг ч хором алдаж болохгүй.

Хүн болгон өөртөө эзэн болж, өөртөө найдна. Тиймээс юуны түрүүн өөрийгөө хянан удирдах хэрэгтэй.

Өөрийгөө удирдаж, хоосон чалчихыг цээрлэж, гүн гүнзгий бодож бясалгавал энэ нь аливаа бачимдлаас ангижрахын эхлэл болно.

Нар өдөр мандаж, сар шөнө гийдэг. Цэрэг эр хувцас дуулгаараа гялалзаж байдаг бол зөв замыг хөөж буй хүн бясалгалаар гялалзаж байдаг.

Нүд, чих, хамар, хэл, бие зэрэг таван мэдрэхүйнхээ үүд хаалгыг хамгаалж үл чадах, гадаад ертөнцийн өнгөнд уруу татагдах хүн бол зөв замаар явж буй бусаа. Таван мэдрэхүйнхээ үүд хаалгыг баттай хамгаалж чаддаг, амгалан тайван хүн бол зөв замаар явж буй юм.

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

7. Ямар нэг юманд дасаж дадсан бол, тэдгээрийн нөлөөн дор хүн эд юмсыг үнэн мөнөөр нь харж чадахгүй. Хэрэв хүн дадаж дассаныхаа хүлээснээс ангижирч чадвал, эд юмсын мөн чанарыг зөв харж чадна. Тиймээс эл хүлээснээс чөлөөтэй болсон сэтгэлд эд юмс шинэ утга чанартай болмой.

Уйтгар гуниг байвал, баяр баясгалан байна. Баяр баясгалан буй цагт уйтгар гуниг ч буй. Тэдгээрээс болон нүгэл, буяны дээр нь байвал дадаж дасахын хүлээс алдарна.

Ирээдүйг мөрөөдөж цаг нь болоогүй юмны төлөө зовж шаналвал, эсвэл зөвхөн өнгөрсний хойноос харамсваас хүн тайрсан хулс лугаа адил хатна.

Хэрэв улирч өнгөрсний хойноос харамсаж гашуудалгүй, ирээдүйн тухай мөрөөдөлгүй, хараахан болж өнгөрөөгүй юмны төлөө санаа зоволгүй, одоо буйг үнэлж сурвал хүний бие, сэтгэлийн аль аль нь эрүүл саруул байна.

Өнгөрснийг харамсан гашуудах, ирээдүйг тэсгэлгүй хүлээх хэрэггүй, харин одоогийн хормыг үнэлээн амьдрах хэрэгтэй.

Өнөөдөр хийх юмыг маргааш больё хэмээн

хойшлуулах хэрэггүй. Өнөөдөр бүтээж болохыгоо найдвартай сайн хийснээр тэр өдрийг үр ашигтай өнгөрүүлнэ.

Итгэл бишрэл нь хүний эрхэм нөхөр, оюун ухаан нь хамгийн сайн газарч бүлгээ. Гэгээрэхийн гэрлийг эрж хайхдаа зовлонгийн харанхуйг тойрч явах хэрэгтэй.

Итгэл бишрэл бол дээд баялаг, чин сэтгэл бол хамгийн сайн мэдрэхүй бүлгээ. Буян үйлдэх нь энэ ертөнцийн хамгийн ариун ажил юм. Бурхан багшийн сургаалын дагуу бие сэтгэлээ засан залж, амар амгаланг олох хэрэгтэй.

Итгэл бишрэл бол энэ хорвоогийн аян замын хоол хтнс юм. Буян бол хүний ариун сайхан орон гэр юм. Оюун ухаан бол энэ ертөнцийн гэрэл гэгээ юм. Зөв санаа бодол нь шөнийн харуул хамгаалалт гэсэн үг. Цэвэр ариун хүн мөнх амьдарна. Хүн ховдог шунахай сэтгэлээ дарснаар эрх чөлөөтэй болно.

Гэр орныхоо төлөө бие юугаан, хот тосгоныхоо төлөө гэр орноо, эх орныхоо төлөө хот тосгоноо мартаарай. Гэгээрэхийн төлөө бол бүгдийг мартаарай.

Бүх юмс хувиран өөрчлөгдөж, буй болж, алга

Бодь мөрийн Зэргийг Олох Арга Зам

болдог. Хүн төрөх, үхэхийн тухай санаа зовж, шаналахаа болимогц нам гүм, энх амгалан байдлыг олдог.